

## Дээд боловсролын мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөр, агуулгын харьцуулсан судалгааны үр дүн

### Үндэслэл

Бүх шатны боловсролын чанар, үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсээс хамгийн эерэг нөлөөтэй нь мэргэжлийн чадамжтай багшийн нөөц гэдэгтэй судлаачид санал нийлдэг. БНСУ-ын Инчон хотноо 2015 оны 5-р сард болсон Дэлхийн боловсролын чуулга уулзалтад оролцогчид Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээн дэх боловсролын ерөнхий хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдийн хүрээг тогтоохдоо “Боловсролын бүх түвшинд үр өгөөжтэй суралцахад багш болон багшлахуйн онцгой чухал үүрэг гүйцэтгэх”-ийг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн.

Багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах үндэслэлийг дараах байдлаар авч үзлээ. Үүнд,

- 1. Боловсролын хувирган өөрчлөлт:* Дэлхий дахинаа боловсрол урьд өмнө хэзээ ч байгаагүй сорилттой тулгарч буй энэ цаг дор суралцахуйн хямралыг цаг алдалгүй шийдвэрлэх нь нэн тэргүүний асуудал болоод байна. Боловсрол дахь ялгаатай байдлыг цар тахал улам хурцатгаж, дэлхийн сая сая хүүхэд үр дагаврыг нь амсаж байна. Улс орнууд яаралтай арга хэмжээ авахгүй бол 2030 он гэхэд ойролцоогоор 84 сая хүүхэд, залуус сургуульд хамрагдаж чадахгүй хоцорч, 300 сая орчим хүүхэд бичиг үсэг тайлагдаагүй, тоо бодох чадваргүй, амжилтанд хүрэх боломжгүй үлдэх болоод байна. Энэхүү тоо баримт нь Монгол Улсад боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах үйл явцыг хурдасгах улмаар иж бүрэн шинэчлэл хийх шаардлагатай гэдгийг илүүтэй тодруулж байна. Эдгээр нь ирээдүйг улам бүр тодорхойгүй болгож байгаагийн зэрэгцээ ирээдүйн боловсролын үзэл баримтлал, бодлого чиглэлийг тодорхой болгохыг шаардаж байна. Ирээдүйн иргэд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хурдацтай өөрчлөлтийг хүлээн авч дасан зохицож чаддаг байхаас гадна хараахан бий болоогүй ажлын байр, хараахан зохион бүтээж амжаагүй технологи, хараахан бий болоогүй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд (OECD, 2018) бэлтгэгдэх хэрэгтэй болж байна. Боловсролын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг нь тухайн нийгэмд амьдрах иргэний асуудал байх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, бид ирээдүйн иргэдийн боловсрол эзэмших эрхийг хангаж баталгаажуулахдаа тодорхойгүй болж буй ирээдүйд иргэдэд чухам ямар ур чадвар шаардлагатайг тодорхойлсны үндсэн дээр тэдэнд зориулсан боловсролын үзэл баримтлалыг боловсруулж, тогтолцоог бүрдүүлэх боломжтой болох учиртай. Боловсролд ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал 1) насан туршдаа суралцах, 2) боловсролд тэгш хамрах, 3) боловсролыг дижиталчлах үзэл санааг чухалчлан авч үзсэн байна.
- 2. Боловсролын цахим шилжилт:* Манай улс ч цар тахлын үед хариу арга хэмжээ авах, ирээдүйд тохиолдож болзошгүй эрсдэлт, гамшгийн нөхцөлд бэлэн байхын тулд цахим, холимог сургалтыг чанартай зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд боловсролын салбарт цахим шилжилтийг хийж байна. Дижитал суралцахуй нь боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад нэгдсэн, шинэлэг хандлага юм. Энэхүү хандлагыг бий болгохын тулд хүний нөөцөө чадавхжуулах, цахим сургалтыг дэмжих технологийг нэвтрүүлэх, цахим сургалтын хөтөлбөрт нийцүүлсэн сургалт,

багш, суралцагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх, хүртээмжтэй, нээлттэй сургуулийн системийг төлөвлөж, байгуулах явдал. Боловсролын цахим шилжилт нь цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан, тэгш, хүртээмжтэй боловсролын тогтолцоог бий болгох шийдэл гэж судлаачид үзэж байна. Ялангуяа хүртээмж, чанарыг сайжруулахын тулд технологид суурилсан шийдлээс гадна дижитал суралцахуйн ач холбогдол, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн суралцагч болон тогтолцооны түвшин дэх саад бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэхтэй холбоотой юм. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/57 тушаалаар “Албан болон албан бус боловсролын сургалтаар иргэдийн эзэмшвэл зохих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээ”-г баталсан. Тус баримт бичгийг хэрэгжүүлснээр хамтран ажилладаг, ухамсартай, бүтээлч цахим Монгол иргэнийг бүтээж, “Цахим үндэстэн” болоход нэг алхам урагшилна. Мөн дижитал технологи нь хувь хүмүүсийг чадавхижуулахаас гадна онлайн болон офлайн орчинд суралцах нийгмийн болон иргэний зорилгыг бэхжүүлэхэд чиглэгдэж байна.

3. *СӨБ болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл:* Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд гарч буй гэнэтийн өөрчлөлт зэргээс үүдэж боловсрол хувьсаж байна. Үүнийг дагаад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байгаа юм. Технологийн дэвшил, хүний хөгжлийн онцлог, хэрэгцээтэй уялдуулан хүн болохуй, суралцахуйн олон янзын, олон талт арга замыг тусгасан хөтөлбөрийг хөгжүүлж, хэрэгжүүлэх шаардлага нэгэнт бий болсон байна. Мөн хүүхэд, залуучуудын суурь чадамж, тэр дундаа тоо тоолол, бичиг үсэг, мэдээлэл харилцаа, технологийн чадамжийг хөгжүүлэх, цар тахал болон бусад хүчин зүйлээс үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх зайлшгүй шаардлага үүссэний зэрэгцээ дижитал төрмөл хэмээгдсэн шинэ үеийнхний өвөрмөц онцлог, мэдээллийн технологийн ололтод тулгуурлан хувь хүний ялгаатай хэрэгцээ, суралцахуйн хэв маягт тохирсон уян хатан, олон хувилбарт сургалтын хөтөлбөрийн шинэчлэл чухал болж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-ын 2.2.-д сургалтын хөтөлбөрөөр суралцагчид эзэмшүүлэх суурь чадамжийг эх хэл, бичиг үсэг, математик, шинжлэх ухаан (байгалийн, нийгмийн), компьютерын ухаан ба цахим технологи, англи хэл, гадаад хэл, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлаар тодорхойлсон бол сургуулийн өмнөх боловсролоос эхлэн цахим технологийн энгийн төсөөлөл, бага боловсролоос эхлэн компьютерын ухааныг судална хэмээн тусгажээ. Түүнчлэн 4.3. -д сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэлийг тодорхойлсон (газар, 2024).
4. *Ерөнхий боловсролын мэдээлэл зүйн багшийн дутагдал:* Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 885 сургууль хичээл, сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 705 буюу 79.7 хувь нь төрийн өмчийн, 180 буюу 20.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна. Мөн бага дунд боловсролын салбарт 61016 ажилтан, багш, албан хаагч ажиллаж байгаагийн 37770 буюу 61.9 хувь үндсэн багш байна. Үүнээс 1041 мэдээлэл зүйн болон математик-мэдээлэл зүйн үндсэн багш ажиллаж байна. Боловсролын яамнаас

2024 оны долдугаар сард хийсэн судалгаагаар ЕБС-д 4292 багш дутагдалтай байна. Үүний 2400 орчим нь Улаанбаатар хотод шаардлагатай гэсэн урьдчилсан дүн гарсан. Харин мэдээлэл зүйн 119 багш энэ хичээлийн жилд дутагдалтай байна (БЯ, esis.edu.mn, 2025)<sup>2</sup>.

5. *Монгол Улсын хэмжээнд “Багш, мэдээлэл зүй” бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулийн болон элсэгчийн тоо хангалтгүй: 2024-2025 оны хичээлийн жилд Монгол Улсад 65 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 34 нь их сургууль, 29 нь дээд сургууль, 2 нь коллеж байна. Үүнээс 17 нь төрийн өмчийн, 45 нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/шашны өмчийн сургалттай. Нийт 150,282 суралцагч байна, үүнээс 54.3% нь төрийн өмчийн, 40.0% нь хувийн өмчийн, 5.7% нь олон нийтийн/шашны өмчийн сургуулиудад суралцаж байна. Монгол Улсын хэмжээнд МУБИС “Багш, мэдээлэл зүй” бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрөөр суралцаж буй боловсон хүчин нь багшийн хомсдолыг бүрэн арилгах боломжгүй. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-ний 2.2.-д Боловсролын салбарын нөөцтэй холбоотой хүн амын өсөлтөд үндэслэн ЕБС-д шаардлагатай багшийг тооцоолоход 2025 он гэхэд 23.576 багш шинээр ажилд авах хэрэгцээ үүсэж байгаа юм. Үүний дотор Мэдээллийн технологийн багшийн эрэлт 2030 он гэхэд 1203 бөгөөд үүнээс 691 нь шинээр ажилд авахаар байна (БШУЯ, 2021).*

### **Судалгааны зорилго, зорилт**

*Судалгааны зорилго:* “Багш, мэдээлэл зүйн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийг сайжруулах санал гаргах.

#### *Зорилтууд*

- Сургалтын хөтөлбөр, багшийн чадамжийн хүрээ, стандартын талаарх мэдээлэл цуглуулах;
- Мэдээлэл зүйн багш бэлтгэж буй бакалаврын сургалтын хөтөлбөрийн нийтлэг болон ялгаатай байдлыг илрүүлэх;
- АНУ-ын Компьютерын ухааны багшийн K12 стандарт болон “Багш, мэдээлэл зүйн боловсрол” бакалаврын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн харьцуулалт хийх;
- Судалгааны өгөгдөл мэдээлэлд боловсруулалт, шинжилгээ хийн нэгтгэх.

### **Судалгааны арга, аргачлал:**

- Мэдээлэл зүйн багш бэлтгэж буй дотоодын болон гадаадын улс орны их сургуулийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн мэдээлэл цуглуулах, нэгтгэх ажлын хуудас боловсруулав. Тус ажлын хуудас нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүн, чадамжийн хүрээ, багц цаг зэргийг агуулсан болно.
- MS Excel программын Pivot table функцийг ашиглах өгөгдөлд дүн шинжилгээ хийх.

### **Судалгааны хамрах хүрээ**

## *А. Судалгааны агуулгын хүрээ*

- Сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүн, багц цаг, судлах улирал г.м.

## *Б. Баримт бичгийн хүрээ*

Дээд боловсролын түвшин дэх судалгааны ажил гүйцэтгэхэд баримталдаг бодлого, эрх зүйн дараах баримт бичгийг шинжилнэ. Үүнд:

1. Бодлого, хууль тогтоомж
  - Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/57 тушаалаар “Албан болон албан бус боловсролын сургалтаар иргэдийн эзэмшвэл зохих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээ”
  - Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл харилцаа, холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага (БЯ, Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага, 2020)
  - “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”
2. Дотоодын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, бусад холбогдох эрх зүйн баримт бичиг
  - a. МУБИС, “Багш, мэдээлэл зүйн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөр (хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүн, сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулга)
  - b. Мэдээлэл зүйн багшийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт; үндэсний болон олон улсын түвшинд цахим шилжилтийн бодлого, хэрэгжилт, чиг хандлага
  - c. АНУ, Австрали, ХБНГУ-ын их сургуулиудын компьютерийн ухааны багш бэлтгэж буй сургалтын хөтөлбөрийн мэдээлэл
  - d. “2020 CS Standards for Computer Science Teachers” (Standards for CS Teachers Downloads, 2025)

## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШИЙН ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ

Дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг төлөвлөх нь хамгийн түрүүнд мэргэжилтний чадамжийн хүрээ, түүний тодорхойлогчийг тодорхой болгохоос эхлэнэ.

Багш мэргэжилтний чадамжийн хүрээг тодорхойлсон үндэсний болон олон улсын судалгаанаас дурдвал “Монгол Улсын 21-р зууны Монгол багшийн загвар”, “Эрдэм чанартай багшийн динамик загвар”, Зүүн Өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ (INNOTECH, 2018), Европын Холбооны гишүүн улсууд багш бэлтгэх хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, багшийн хөгжих хэрэгцээг тодорхойлох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихийн тулд боловсруулсан “21-р зууны Багшийн

цогц чадамжийн хүрээ”, Испани улсын Барселонагийн Их Сургууль, Португал улсын Коимбрагийн Их Сургууль, Английн Ноттингем Трентийн Их Сургууль, БНХАУ-ын Бээжингийн Багшийн Их Сургууль, Баруун хойд болон Баруун өмнөд Багшийн Их Сургуулийн багш, эрдэмтэд хамтран боловсруулсан “Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ”, 2019 онд ЮНЕСКО-оос боловсруулсан “Багшийн мэргэжлийн стандартын дэлхий дахины хүрээ” (UNESCO, 2019) зэргийг нэрлэж болно. Эдгээр стандарт, чадамжийн хүрээ тодорхойлсон баримт бичгүүдийг харьцуулан үзвээс 1) Багшлахуй-суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөх, 2) Багшлахуй (Багшлахуйн үр дүнтэй арга, багшлах ур чадвар, арга зүйн сонголт, эерэг орчин бүрдүүлэх, анги удирдах), 3) Үнэлгээ хийх, 4) Олон нийттэй хамтран ажиллах, 5) Өөрийгөө эргэцүүлэх ба мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх, 6) Бусадтай харилцахтай, 7) Тэгш хамруулах, 8) Багшийн мэдлэг, ойлголт (Судлагдахууны агуулгын, заах арга арга зүйн агуулгын, заах арга зүйн, суралцагчийн талаарх, боловсролын бодлого, чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн, боловсролын шинжлэх ухааны, судалгааны арга зүйн, хөгжлийн сэтгэл судлалын, судалгаанд суурилсан мэдлэг), 9) Суралцахуйг дэмжих (чиглүүлэх, зохион байгуулах, урамшуулан сайшаах, суралцагч болон бүлгийг удирдах) нь бүгдэд нь агуулагдсан байна. Харин мэдээлэл, харилцаа холбооны технологитой холбоотой чадамжийн тухайд зөвхөн Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ болон Европын Холбооноос гаргасан Багшийн цогц чадамжийн хүрээнд агуулагдсан байна.

Монгол Улс нь 2018 онд батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна” (МУИХ, Багшийн хөгжлийн дэмжих тухай хууль, 2018)<sup>1</sup> гэж заасан байна. Мөн Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын Зорилт 2.1.-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн боловсролтой холбоотой зорилгын хүрээнд “Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана” гэжээ (МУИХ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020). Энэхүү зорилтод хүрэхийн тулд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд:

- “2.1.34. Багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа, холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана”,
- “2.1.44. Багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх ..... сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх

---

<sup>1</sup> <https://legalinfo.mn/mn/detail/13532>

төрлийн байгууллагын оролцоог хангана” гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын багшийн ажлыг үнэлэхэд баримтлах дараах шалгуур, үзүүлэлтүүд батлагдсан (МУЗГ, 2022). Үүнд:

1. Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн
2. Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн
3. Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн
4. Сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр

Дээрх бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэн дүгнэвэл Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтээ багшийг дараах чадамжтай байхаар бэлтгэж, хөгжүүлэхээр зорьж байна. Үүнд:

1. Мэдээлэл, харилцаа, холбооны технологийн мэдлэг, чадвар;
2. Гадаад хэл, тэр дундаа англи хэлний чадвар;
3. Мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны мэдлэг, чадвар орж байна. Үүнээс гадна багшийн хандлага, ёс зүй, мэргэжлийн хөгжил, олон нийттэй хамтран ажиллах, суралцагчид үзүүлэх дэмжлэгийг чухалчилсан байна.

*Хүснэгт 1. Үндэсний болон олон улсын чадамжийн хүрээ, стандартын харьцуулалт (БСҮХ, 2022)*

Олон улсын болон дэлхийн хэмжээний багшийн цогц чадамжуудын хүрээг харьцуулан шинжилсний үр дүн	Монгол Улсын багшийн загвар болон гадаад улс орны багшийн цогц чадамжуудын хүрээг харьцуулан шинжилсний үр дүн	Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичгүүдээс багшийн чадамжтай холбогдох зүйлс	Бусад олон улсын чадамжийн хүрээгээс онцлог зүйлс
Багшлахуй-суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөх	Хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах (Монгол)		
Багшлахуй (Багшлахуйн үр дүнтэй арга, багшлах ур чадвар, арга зүйн сонголт, эерэг орчин бүрдүүлэх, анги удирдах)	Заах арга зүй чадвар, суралцах орчин бүрдүүлэх, суралцах үйл ажиллагааг чиглүүлэх	Заах арга зүйн чадвар	
Үнэлгээ хийх	Үнэлгээ, сургалтын үр дүнг үнэлэх, тайлагнах		
Олон нийттэй хамтран ажиллах		Олон нийттэй хамтран ажиллах	

Өөрийгөө эргэцүүлэх ба мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх	Мэргэжлийн хөгжил (Австрали)	Мэргэжлийн тасралтгүй хөгжил	Өөрийгөө үнэлэхүй, эргэцүүлэхүй, шүүмжлэлт үнэлгээ, бие даан суралцах
Бусадтай харилцах	Харилцааны чадвар		Хун хоорондын харилцааны чадвар
Тэгш хамруулах	Тэгш хамрагдалт, ялгаатай байдлыг хүндэтгэх		
Багшийн мэдлэг, ойлголт	Мэдлэг, ойлголт (суралцагч, судлагдахуун, заах арга зүй, боловсролын бодлого, эрх зүй, сургалтын хөтөлбөр, үнэлгээний талаарх мэдлэг, ойлголт)	Мэргэжлийн мэдлэг, чадвар	Сургалтын луужин 2030 (Суралцагчийн талаарх мэдлэг) Хууль, бодлого, засаглал
Суралцахуйг дэмжих (чиглүүлэх, зохион байгуулах, урамшуулан сайшаах, суралцагч болон бүлгийг удирдах)		Суралцагчид үзүүлэх дэмжлэг	Суралцагчийн суралцахуй ба хөгжил
<i>Мэдээлэл, харилцаа холбооны технологи</i>	<i>Мэдээлэл, харилцаа холбооны технологи</i>		<i>Багшийн мэдээлэл харилцаа, технологийн чадамж (Боловсрол дахь МХТ-ийн ойлголт, сургалтын хөтөлбөр болон үнэлгээ, заах арга зүй, дижитал ур чадварын хэрэглээ, удирдлага, зохион байгуулалт, багшийн мэргэжлийн сургалт)</i>

Гадны улс орнууд дээрх багшийн чадамжийн хүрээ, стандартын зэрэгцээ шинжлэх ухааны чиглэл, судлагдахуун бүрээр багш бэлтгэх стандартыг боловсруулан хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллага нь хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгээ тухайн салбарын бодлого, сургалтын байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратегийн бодлого, зорилтуудтай уялдуулан боловсруулахаар хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан байдаг.

Энэхүү судалгаанд “2020 CS Standarts for Computer Science Teachers” компьютерийн ухааны багшийн стандартыг МУБИС-ийн мэдээлэл зүйн багшийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй харьцуулан үзлээ.

“2020 CS Standarts for Computer Science Teachers” стандартын гол зорилго нь 2-12-р ангийн сурагчдад компьютерийн шинжлэх ухааны мэдлэг, чадварыг үр дүнтэй, тэгш хүртээмжтэй хүргэх талаар тодорхой удирдамж өгөх зорилготой бөгөөд энэхүү зорилго нь дараах үйл ажиллагаагаар хэрэгжинэ. Үүнд:

- Багш нар ангидаа юу мэдэж, юу хийх чадвартай байх ёстойг тайлбарлах,
- Багш нар мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжих хүсэл эрмэлзэлтэй болгоход дэмжих,
- Багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих багт чадамжийн стандартын жишиг тогтоох юм.



Хүснэмт 2. 2020 CS Standarts for Computer Science Teachers

Ай/ стандарт	Чадамж	Тодорхойлолт
Компьютерын ухааны мэдлэг ба чадвар	Мэдээллийн технологийг хэргэлдэг	Уян хатан байдлаар компьютерын ухааны ойлголтуудыг болон тооцоолох чадвартай болж. Дадлагын дараах чадваруудыг эзэмшсэн: ажиллагаанд тооцоолох соел, хамтын үйл ажиллагаа, тооцоолох асуудлаа ойлгох, тодорхойлох. хийсвэрлэнэ сэтгэх, программ хөгжүүлэх, тестлах, эцэслэх
	Тооцооллын мэдлэгийг хэрэглэх	Техник, программ хангамж ашиглаж чаддаг, мэдээлэл боловсруулах, хадгалах, үр дүнг гаргах, дүн шинжилгээ хийх, төсөл боловсруулах, алга засаж сайжруулах
	Сүлжээ ба интернэт	Загварчлах / сүлжээнгий топологи гаргах/, компьютеруудыг сүлжээ ба интернэтэд холбох, сүлжээ хэрэглэх боломж болон аюулгүй байдал
	Өгөгдөл хэрэглэх, дүн шинжилгээ хийх	Өгөгдөл цуглуулах, хадгалах, хувиргах, дүн шинжилгээ хийх, таамаглал дэвшүүлэх.
	Программ хөгжүүлэх, алгоритмыг тайлбарлах	Программ хөгжүүлэлтийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх,зохих технологи ашиглан турших. Алгоритм тайлбарлах, өөр хөгжүүлэлтэд хэрэглэх.
	Тооцоолох нөлөөллийн шинжлэх	Нийгмийн хөгжил тооцоололд хэрхэн нөлөөлдөг, тооцоолол нийгэмд эерэг ба сөрөг байдлаар нөлөөлөл
Тэгш болон хүртээмжтэй байдал	Цахим хуваагдлыг асуудлыг судлах	Цахим хуваагдал нь маргенал бүлгүүдийн МХХТ-ийн хүртээмж, оролцоонд нөлөөлөл судлах. КУ-ын тэгш, хүртэмжтэй сургалт зохион байгуулах асуудлууд өөрсдийн сургаалын хүрээнд зохион байгуулах.
	Тэгш бус байдлыг багасгах	КУ-ын сургалтад тэгш бус байдлыг багасгах стратеги баримтлах

	Янз бүрийн үзэл бодлыг сургалтад тусгах	Сургалтын агуулга, сургалтын хэрэглэгдэхүүн, удирдамжд олон янзын бүлгүүдийн үзэл бодол болон туршлагыг тусгах
	Тэгш, хүртээмжтэй сургалт зохион байгуулахад өгөгдөл, мэдээлэл дээр суурилж шийдвэр гаргах	Хүртээмжтэй, суралцагч бүрийн оролцоог хангасан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
	Нээлттэй сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах	Сургалтын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүнийг нээлттэй хэрэглэх боломжийг үнэлэх, суралцагчдад хүртэмжтэй байлгах
Мэргэжлийн өсөлт болон өөрийн онцлог	Зорилтот мэргэжлийн хөгжилд хүрэх	Байнгын мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх. Компьютерийн шинжлэх ухааны агуулга, заах арга зүй мэдлэг, ур чадвараа гүнзгийрүүлэх.
	Тасралтгүй суралцах загвар	Бусдаас суралцах, шинэ ур чадвараа байнга хөгжүүлэх хүсэлтэй байгаад үлгэр жишээгээр үзүүлэх. Шинэ болон төвөгтэй асуудлыг шийдвэрлэхдээ итгэлтэй, тууштай байдлаа харуулах.
	Хувийн зан араншин, үзэл бодол мэдэх	Суралцагчдын үзэл бодол, эрх мэдэл нь тэдний сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж байгааг мэдэх. Суралцагчдын болон ангийн соёлыг сурталчлах.
	Бүх нийтийн компьютерийн шинжлэх ухааны эрхэм зорилгод үнэнч байх	Компьютерын ухааныг заах өөрийн философитэй байх, үүнд суралцагч бүр КУ мэдлэг байх ёстой гэсэн үзэл бодолтой
	Олон нийтийн нөөцийг ашиглах	Орон нутгийн болон илүү өргөн экосистемийн нөөцийг тодорхойлж, нэгтгэж, суралцагчдад компьютерийн шинжлэх ухааныг сурахад дэмжлэг үзүүлэх ашиглах.
	Мэргэжлийн компьютерын ухааны сургалтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцох	Компьютерийн шинжлэх ухааны мэргэжлийн сургалтын нийгэмлэгүүдэд (PLCs) оролцох, хамтран ажиллах, сургалтын арга зүйн туршлага хуваалцах, хамтран асуудлаа шийдэх.
	КУ сургалтын хөтөлбөрийг шинжлэх	Компьютерийн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөрийг ангидаа хэрэгжүүлэхэд нь дүн шинжилгээ хийх. Үүнд: Мэдээллийн технологийн стандартад нийцсэн байдал, агуулгын хувьд үнэн зөв, бүрэн бүтэн байдал, соёлын хамаарал, хүртээмжтэй байдал.
Суралцахуйн дизайн	Стандартад нийцсэн суралцахуйн дизайныг боловсруулах	Стандартад нийцсэн КУ сургалтыг зохион байгуулах
	Хүртэмжтэй сургалт зохион байгуулах	Суралцагч бүрт хүрсэн сургалтын арга зүй хэрэглэх

	КУ агуулгыг бусад судлагдахууны агуулгатай интеграцчлах	КУ агуулгыг бусад судлагдахууны агуулгатай интеграцчлах
	Суралцагчийн хөгжлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлэх	Нээлттэй, хувь хүний хөгжлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлэх
	Сургалтын төлөвлөгөө боловсруулах	КУ сургалт зохион байгуулах сургалтын төлөвлөгөө боловсруулах
Танхимын сургалт	Судалгаанд суурилсан сургалт зохион байгуулах	Суралцагчид КУ агуулгыг сайн ойлгохын тулд судалгаанд суурилсан сургалт зохион байгуулах
	Ая тухтай, найрсаг орчин бүрдүүлэх	Олон талд үзэл бодлыг дэмжсэн найрсаг орчин бүрдүүлэх
	Суралцагчдын бие даах чадварыг урамшуулах	Суралцагчдын бүтээлч байдлыг дэмжих, бие даан ажиллах чадварыг урамшуулах.
	Суралцагчдын хамтын ажиллагааг дэмжих	Суралцагчдыг багаар ажиллах боломж бүрдүүлэх.
	Суралцагчдын харилцааг дэмжих	Суралцагчдын харилцааг дэмжих
	Суралцагчдыг эргэх холбоо тогтооход дэмжих	Суралцагч - суралцагч. багш- суралцагч нарын эргэх холбоо тогтооход дэмжих

### МУБИС-ИЙН “БАГШ, МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛ” БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Тус хөтөлбөрөөр элсэлт, төгсөлт хийж, хэрэгжүүлсэн гэдэг утгаар 2016 онд боловсруулагдан 2018 онд сайжруулалт хийгдсэн МУБИС-ийн “Багш, мэдээлэл зүйн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийг сонгон шинжилгээ хийв. MS Excel программын Pivot table функцийг ашиглан мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ дараах хүснэгтийн дагуу цуглуулсан сургалтын хөтөлбөрийн мэдээллийг (сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, хичээлийн товч агуулга, улирал, багц цаг г.м.) ашиглав.

*Зураг 1. Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл цуглуулсан байдал*

№	Агуулга	Хичээлийн код, нэр	CLO хичээлээр эзэмших үр чадварууд	PLO хөтөлбөрөөр эзэмших үр чадварууд	Судлах улирал	C2 Стандарт
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	1.1 Мэдээлэл харилцааны технологийн хөгжлийн зүй тогтол, боловсрол болон сургалтын үйл ажиллагаа дахь мэдээлэл харилцааны технологийн хэрэглээг эргэцүүлэх, тайлбарлах	PLO 1.1.3	I	
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	1.2. Интернэт дэх мэргэжлийн холбогдолтой эх үүсвэрүүдийг судлах, зохистой хэрэглээний талаар ойлголтой болох	PLO 1.1.3	I	
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	1.2. Интернэт дэх мэргэжлийн холбогдолтой эх үүсвэрүүдийг судлах, зохистой хэрэглээний талаар ойлголтой болох	PLO 1.2.3	I	
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	2.1 Боловсролын нээлтэй нөөц, МХТ-ийн боломж, нийгмийн сүлжээ болон сургалтын техник, тоног төхөөрөмжийг сургалтад үр бүтээлтэй ашиглах	PLO 1.1.4	I	
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	2.2 Сургалтын холбогдолтой бичиг баримт, хүснэгтэн мэдээлэл, үзүүдэн боловсруулах	PLO 1.1.4	I	
заавал	Ерөнхий суурь	Мэдээлэл харилцааны технологи	2.3 Цахим хэрэглэгдэхүүн болон цахим үнэлгээний материалыг өөрийн мэргэжлийн онцлогт тохируулан боловсруулах	PLO 1.1.4	I	

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хичээл бүрийн оруулах хувь нэмрийг хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Суралцахуйн үр дүнд хичээлүүдийн оруулах хувь нэмэр

Row Labels	Grand Total	Кр/ц	Row Labels	Grand Total	Кр/ц
Математик анализ-1	42	3	Компьютерийн үндэс	8	2
Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй	34	2	Мэдээллийн технологийн англи хэл	8	1
Суралцахуй ба багшлахуйн үндэс	33	3	Өгөгдлийн бүтэц	8	3
Онлайн сургалтын арга зүй	29	2	Сургалтын цахим агуулга боловсруулах аргазүй	8	2
Сургууль судлал	29	2	Багш мэргэжлийн удиртгал	7	1
Шугаман алгебр, аналитик геометр-1	23	3	Интернэт программчлал	7	
Сургалтын онол, арга зүй	19	3	Компьютер алгебрын систем	7	
Монгол хэл бичиг, найруулгазүй	18	3	Компьютерийн архитектур ба зохион байгуулалт	7	2
Биеийн тамир	15	1	Компьютерийн сүлжээ	7	2
Логик, олонлогийн онол	15	2	Математик хэвлэлийн эх бэлтгэх систем	7	2
Судалгааны аргазүй	15	2	Мэдээлэл зүйн бодлого бодох семинар	7	2
Хүний хөгжлийн сэтгэл судлал	15	2	Сургуулийн информатик	7	2
Боловсролын сэтгэл судлал	14	3	Сүлжээний техник хангамж, менежмент	7	2
Мэдээлэл зүйн сургалтын арга зүй II	14	3	Тооцон бодох математик	7	2
Нэгдмэл арга зүй	13	2	Англи хэл I	6	3
Програмчлалын хэл-2	13	2	Монгол бичиг	6	2
Хүүхэд хамгаалал	13	1	Мультимедиа технологи, визуалчлал	6	2
Монголчуудын түүх, соёл	12	1	Үйлдлийн системийн зарчим	6	2
Мэдээллийн систем	12	2	Хөтөлбөр судлал	6	1

Гамшгаас хамгаалах менежментийн үндэс	11	1	Визуаль програмчлал	5	3
Багшийн ёс зүй	10	1	Жава технологи	5	2
Байгалийн ухаан	10	2	Сэтгэлгээний түүх, соёл	5	3
Компьютерийн мэдээллийн хамгаалалт, криптографын үндэс	10	2	Ухаалаг систем	5	2
Эрүүл мэнд, амьдрах ухаан	10	2	Хэрэглээний програмууд	5	2
Алгоритм	9	3	Эрх зүй	5	2
Англи хэл II	9	2	Боловсролын хэмжил зүй	4	3
Компьютер загварчлал ба симуляци	9	1	Орос хэл	4	2
Мэдээлэл зүйн сургалтын арга зүй I	9	3	Хятад хэл	4	2
Мэдээлэл харилцааны технологи	9	2	Даяаршил ба соёл	1	2
Объект хандалтат програмчлал	9	2	Жендэр ба Тогтвортой хөгжил	1	2
Өгөгдлийн сан	9	3	Математикийн ухаан	1	2
Програмчлалын хэл-1	9	3	Тусгай хэрэгцээт боловсролын үндэс	1	2
Бүтээлч сэтгэлгээ	8	3	Улс төр судлал	1	2
Веб програмчлал /дизайн	8	2	Эдийн засаг	1	2
Ерөнхий сэтгэл судлал	8	2	Экологи, байгаль хамгаалал	1	2

Дээрх хүснэгтээс харахад МУБИС-ийн сургалтын хөтөлбөр дэх хичээлүүдийн 718 суралцахуйн үр дүнд дараах зүйл харагдаж байна. Үүнд:

- Математик анализ-1, Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй, Суралцахуй ба багшлахуйн үндэс, Онлайн сургалтын аргазүй, Сургууль судлал, Шугаман алгебр, аналитик геометр-1, Сургалтын онол, арга зүй зэрэг мэргэжлийн суурь хичээлүүд нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн 30 орчим хувьд хамаарч байгаа бөгөөд нийт багц цагийн 12.8 хувийг эзэлж байна.
- Сургалтын хөтөлбөрийн зарим суралцахуйн үр дүн нь зөвхөн 1 л хичээлээр олгогдохоор төлөвлөгдсөн (тогтвортой хөгжил, тэгш хамруулах боловсрол, мэдээллийн боловсрол, соёл) нь багш нар хичээлийн хөтөлбөр, хичээлийн суралцахуйн үр дүнг төлөвлөхдөө харилцан уялдаа холбоогүй боловсруулсныг илтгэж байна. Мэргэшүүлэх хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн нь мөн салангид байдлаар боловсруулагдсан.

### **Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн**

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн талаар товч авч үзье. Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн сургууль төгсөх үедээ эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалтыг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн гэнэ. Өөрөөр хэлбэл оюутан төгсөх үедээ юу мэддэг, юуг хийж чаддаг, ямар хандлага төлөвшилтэй болсон байхыг илэрхийлэх үр дүнгийн жагсаалт гэж хэлж болно. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалаар суралцахуйн үр дүнгүүдийг өөр өөр түвшинд дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Тухайн дээд боловсролын байгууллагын сургалтын чиглэлээр баримтлах урт хугацааны бодлого талаас нь тодорхойлох (Алсын хараа, эрхэм зорилго)


- Хөтөлбөрөөр суралцаж төгссөн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар, хандлагын түвшин талаас нь тодорхойлох (Хөтөлбөрийн боловсролын зорилт (PEOs-Program Educational Objectives))
- Хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутны сургалтын нийт хугацаанд эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага талаас нь тодорхойлох (Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs-Program Learning Outcomes))
- Хөтөлбөрт хамаарах хичээлүүдээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага талаас нь тодорхойлох (Хичээлийн суралцахуйн үр дүн (CLOs-Course Learning Outcomes)) зэрэг юм.

*Хүснэгт 4. Хичээлийн суралцахуйн үр дүн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлээр*

Count of №				
CLOs	Ерөнхий суурь	Мэргэжлийн суурь	мэргэшүүлэх	Grand Total
Нийт	145	355	218	718

Дээрх хүснэгтээс харахад хөтөлбөрийн 718 суралцахуйн үр дүнгийн 20 хувь нь ерөнхий суурь хичээлээр, 49 хувь нь мэргэжлийн суурь хичээлээр, 30 хувь нь мэргэшүүлэх хичээлээр хэрэгжихээр төлөвлөгдсөн байна. “Суралцахуйн зүй тогтол, түүнийг сургалт зохион байгуулахад харгалзах” суралцахуйн үр дүн – 69 удаа, “Тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг хэрхэн бүтээх, бүтэцлэх, бусад хичээлийн агуулгатай холбох, амьдралд хэрэглэх” суралцахуйн үр дүн - 53 удаа давтагдаж байгаа, зарим суралцахуйн үр дүнгүүд мэргэжлийн суурийн 1-2 хичээлээр олгохоор төлөвлөгдсөн зэрэг нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хуваарилалт харилцан адилгүй томъёолсныг харуулж байна.

*Зураг 2. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хуваарилалт (түвшингээр)*



Дээрх зургаас хэд хэдэн дүгнэлт хийхээр байна.

- Багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшилд хамаарах хөтөлбөрийн суралцахуйн үр дүн 1-р түвшинд, хувь хүний суурь мэдлэг, чадвар, хандлагад хамаарах суралцахуйн үр дүн 2-р түвшинд, багш мэргэжлийн болон суралцагчийн төлөвшлийг дэмжих мэдлэг, чадварт хамаарах суралцахуйн үр дүн 3-р түвшинд, мэргэжлийн мэдлэг, чадварт хамаарах суралцахуйн үр дүн 3, 4-р түвшинд тус тус төлөвлөгдсөн байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг томъёолохдоо тодорхой бус, үнэлэхэд бэрхшээлтэй, утгын давхцалтай, хэтэрхий олноор томъёолсон байна.

## КОМПЬЮТЕРЫН УХААНЫ БАГШИЙН К12 СТАНДАРТ БА МУБИС-ИЙН "МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БАГШ" ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү харьцуулсан шинжилгээ нь МУБИС-ийн "Мэдээлэл зүйн багш" хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs) болон Компьютерын ухааны багшийн К12 стандартын таван үндсэн ай (domain)-г хэрхэн ижил төстэй болон нийцэл хэр байгааг судалсан болно.

МУБИС-ийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь К12 стандартын шаардлагыг хангах хоёр гол цогц чадамжийг төлөвшүүлэхээр зохион байгуулагдаж байна:

1. Ерөнхий багшлах ур чадвар (К12-ын Ай 2, 3, 5): Хөтөлбөрийн 1-р (Үнэт зүйл, ёс зүй) ба 2-р (Боловсрол судлал, арга зүй) бүлгийн PLOs нь багшийн мэргэжлийн өсөлт, тэгш хүртээмжтэй байдал, танхимын сургалтыг удирдах чадамжийг бүрэн хангаж байна.
2. Мэргэжлийн (Компьютерын ухаан) чадвар (К12-ын Ай 1, 4): Хөтөлбөрийн 4-р (Мэдээлэл зүй) бүлгийн PLOs нь компьютерын ухааны гүнзгий мэдлэг, суралцахуйн дизайныг боловсруулах чадамжийг тусгайлан эзэмшүүлдэг.

### **Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба ай тус бүрийн харьцуулалт**

#### Ай 1: Компьютерын ухааны мэдлэг ба чадвар

- К12-ын шаардлага: Багш нь программчлал, алгоритм, сүлжээ, өгөгдлийн сан, технологийн нийгмийн нөлөөлөл зэрэг компьютерын ухааны цөм ойлголтуудыг гүнзгий эзэмшсэн байх.
- МУБИС-ийн хөтөлбөрт туссан байдал: Энэ бол хөтөлбөрийн PLOs 4-ийн ( 4.1, 4.2) шууд зорилго болгож орсон байна. Хөтөлбөр нь онолын мэдлэгийг маш тодорхой, практик ур чадварууд болгон задалсан:
  - Программчлал ба алгоритм (4.1.2, 4.2.2, 4.2.3): Зүгээр нэг "программчлах" биш, "процедур ба объект хандалтат", "өгөгдлийн бүтэц"-ийг ойлгох, "алгоритмыг харьцуулах, шинжлэх" гэх мэт гүнзгий чадамжийг шаарддаг.
  - Технологийн хэрэглээ (4.2.6, 4.2.7, 4.2.14): "Веб, визуаль программ" боловсруулах, "сүлжээ зохион байгуулах", "үүлэн тооцоолол, интернэт" ашиглах зэрэг орчин үеийн бүхий л хэрэгцээг тусгасан.
  - Өгөгдөл ба шинжилгээ (4.2.5): "Өгөгдлийн сан бүтээх, боловсруулах" гэж тодорхой заасан.
  - Нийгмийн нөлөөлөл (4.3.2, 4.3.3): Технологийн хөгжлийн "нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө"-г эргэцүүлэх, "ёс зүйтэй хэрэглээ"-г төлөвшүүлэх хандлагыг шаарддаг.

МУБИС-ийн хөтөлбөр нь K12 стандартын шаарддаг техникийн бүх чадамжийг бүрэн хангаж байна. Мэдээлэл зүйн хөтөлбөрөөр сурсан төгсөгч мэргэжлийн техник, технологийн чадамж өндөр байхаар туссан байна.

### Ай 2: Тэгш болон хүртээмжтэй байдал

- K12-ын шаардлага: Багш нь суралцагчдын ялгаатай байдал (соёл, нийгэм, эдийн засаг, танин мэдэхүй)-ыг ойлгодог, хүндэтгэдэг, бүх сурагчдад тэгш боломж олгох, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлдэг байх.
- МУБИС-ийн хөтөлбөрт туссан байдал: Хөтөлбөрийн PLOs 1 (Үнэт зүйл) болон PLOs 2 (Боловсрол судлал)-ын үндсэн хэсэг юм.
  - Ялгаатай байдлыг хүндэтгэх (1.1.1, 1.2.4): "Суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг мэдэх, ойлгох, хүндэтгэх", "Соёлын ялгааг ойлгох".
  - Хүүхэд бүрийг дэмжих (1.1.2, 2.1.1, 2.1.3): "Хүүхэд бүрд амжилттай сурч чадна гэдэг итгэл өгөх", "хувийн болон насны онцлогийг судлах", "хөгжил төлөвшилд цогц хандаж... дэмжих, зөвлөх".

Бакалаврын хөтөлбөр нь "мэдээлэл зүйн багш"-ийг бэлтгэхдээ юун түрүүнд "багш" байхын тулд ёс зүйтэй байхыг заасан байна. Энэ нь K12 стандартын "тэгш, хүртээмжтэй байдал" гэсэн шаардлагыг бүрэн хангаж, "технологи" болон "хүмүүнлэг" зарчмыг боловсролд тэнцвэржүүлж байна.

### Ай 3: Мэргэжлийн өсөлт болон өөрийн онцлог

- K12-ын шаардлага: Багш нь тасралтгүй суралцаж, хөгжиж байх болон мэргэжлийн хамт олонтойгоо идэвхтэй харилцаж, өөрийн үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийдэг байна гэж туссан.
- МУБИС-ийн хөтөлбөрт туссан байдал: Хөтөлбөр нь багшийг "нэг удаа бэлтгэгдээд дуусдаг" биш, "тасралтгүй хөгжигч" байхаар төлөвшүүлдэг.
  - Тасралтгүй суралцах (2.2.5, 4.3.2): "Шинэ санаа, шинэчлэлийг соргогоор мэдрэх, зохицох", "шинээр гарч буй дэвшлийг соргогоор хүлээн авах".
  - Өөрийн үнэлгээ (2.4.8): "Багшлах үйл явцаа үнэлэх, өөрийн хөгжих хэрэгцээг тодорхойлох".
  - Манлайлал ба Хамтын ажиллагаа (4.3.4, 4.2.11): "Бусад мэргэжлийн багш нарын МХТ-ийг... хэрэглэх үйлд дэмжлэг үзүүлэх", "хамтын ажиллагааг зохион байгуулах".

Бакалаврын хөтөлбөр нь K12 стандартын шаардлагыг хангаад зогсохгүй, "манлайлагч багш" бэлтгэх зорилт тавьсан байна. Ялангуяа PLO 4.3.4 (бусад багш нарт дэмжлэг үзүүлэх) нь тухайн багшийг зөвхөн өөрийн ангидаа биш, сургуулийнхаа хэмжээнд технологийн манлайлагч, зөвлөх байхыг шаардаж байна.

#### Ай 4: Суралцахуйн дизайн

- К12-ын шаардлага: Багш нь стандартыг ойлгож, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний даалгавар боловсруулж чаддаг, мөн КУ-г бусад хичээлтэй холбож, төсөлт ажил зохион байгуулж чаддаг байх.
- МУБИС-ийн хөтөлбөрт туссан байдал: PLO (Арга зүй) болон PLO 4 (Мэргэшил)-ийн чадамжууд.
  - Ерөнхий төлөвлөлт (2.3.4, 2.4.3): "Боловсролын бодлого, стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх", "сургалтыг төлөвлөх".
  - Компьютерын ухааны сургалтын төлөвлөлт (4.2.12, 4.2.13, 4.2.15): "Цахим агуулга, хэрэглэгдэхүүн боловсруулах", "МХТ-д суурилсан сургалтын онцлогийг мэдэх, түүнийг зохион байгуулах", "орчин үеийн аргуудыг хэрэглэх".
  - Төсөл ба интеграци (4.2.8, 4.2.10): "Үзэгдлийн... загвар боловсруулах, программчлах" (Төсөлт ажлын үндэс), "бусад агуулгатай холбох, интеграцчилах".

Бакалаврын хөтөлбөр нь багшийг зүгээр нэг "хэрэглэгч" биш, харин "МХТ-д суурилсан сургалтыг бүтээгч, дизайнер" байхыг шаардаж байна. Мэдээлэл зүйн багш хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна, өөрсдөө *цахим агуулга боловсруулж* (4.2.12), *МХТ-д суурилсан сургалтыг зохион байгуулж* (4.2.13) чаддаг байх ёстой. Энэ нь К12 стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

#### Ай 5: Танхимын сургалт

- К12-ын шаардлага: Судалгаанд суурилсан заах арга зүйг ашиглах, эерэг, найрсаг орчин бүрдүүлэх, сурагчдын хамтын ажиллагааг дэмжих, үр дүнтэй эргэх холбоо өгөх.
- МУБИС-ийн хөтөлбөрт туссан байдал: PLO 2.4 (Арга зүй) болон PLO 1.1 (Суралцагчид хандах хандлага) суралцахуйн үр дүнд орсон байна.
  - Арга зүй (2.4.5): "Сурах, сургах аргуудыг оновчтой сонгох, бүтээлчээр хэрэглэх".
  - Орчин бүрдүүлэх (2.2.3, 2.4.6): "Сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх", "суралцах таатай орчныг бүрдүүлэх".
  - Үнэлгээ ба эргэх холбоо (2.4.7, 1.1.3): "Суралцагчдын... өөрчлөлтийг үнэлэх", "амжилт, ахиц дэвшлийг урамшуулах, үнэлэх".
  - Удирдан чиглүүлэх (1.1.4, 2.1.3): "Суралцах үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх".

МУБИС-ийн хөтөлбөр нь уламжлалт "мэдлэг дамжуулагч"-ийн загвараас татгалзаж, орчин үеийн, суралцагч төвтэй, бүтээлч (constructivist) хандлагыг баримталж буйг тодорхой харуулж байна. Энэ нь K12 стандартын шаардлагатай нийцэж байна.

Дүгнэлт: МУБИС-ийн "Мэдээлэл зүйн багш" бакалаврын хөтөлбөр нь Багшийн K12 стандартын шаардлагыг бүрэн хангасан хөтөлбөр байна.

Энэхүү хөтөлбөрийн давуу тал нь K12 стандартын таван айг зүгээр нэг "онолын" түвшинд биш, харин суралцахуй үр дүн 1, 2-т багшийн ерөнхий ур чадвар, суралцахуйн үр дүн 4-т мэдээлэл зүйн мэргэшлийн ур чадварыг эзэмшүүлж байна.

Өөрөөр хэлбэл, энэ хөтөлбөрөөр төгсөгч нь зөвхөн "код сайн бичдэг программист" эсвэл "хүүхэдтэй сайн харьцдаг багш" биш, харин "Компьютерын ухааныг хэрхэн үр дүнтэй, хүртээмжтэй заахаа мэддэг, сургалтын хэрэглэгдэхүүнээ өөрөө бүтээж чаддаг, тасралтгүй хөгжигч мэргэжилтэн" болон төлөвших бүрэн боломжтой байна.

## МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БАГШ БЭЛТГЭХ ДОТООД, ГАДААДЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

МУБИС-ийн хэрэгжүүлж буй "Багш, мэдээлэл зүйн боловсрол" бакалаврын сургалтын хөтөлбөрийг Германы Дрездены Техникийн Их Сургууль "Багш, мэдээлэл зүйн боловсрол", АНУ-ийн Дрексел Их сургуулийн /Drexel university/ болон Меркер Их Сургуулийн /Mercer university/ "Багш, компьютерын ухаан"-ийн бакалаврын хөтөлбөрүүдийг харьцуулж үзэхэд дараах үр дүн харагдаж байна.

### 1. МУБИС-ийн хөтөлбөр нь "Багш" төвтэй".

- Дидактик /математикийн багш суурь боловсролын агуулгаас гадна мэргэшлийн компьютерийн ухааны боловсрол буюу программчлал, AI хиймэл оюун, Мобайл, Кибер аюулгүй байдал зэрэг орчин үеийн агуулгыг судалж байна.

### 2. Олон улсын хөтөлбөрүүд (Дрезден, Drexel, Mercer): Компьютерийн ухааны цөм агуулгатай.

- Компьютерийн шинжлэх ухааны агуулгаас гадна багш боловсролын агуулгыг судалж байна. Өөрөөр хэлбэл, компьютерийн шинжлэх ухааны/инженерийн (CSC, IST хичээлүүд) суурь хичээлээс гадна боловсрол судлал, арга зүйн (багшлахуй, үнэлэх, ангийн менежмент) агуулгыг судалдаг.
- Drexel University (АНУ): "Инженер-багшийн хөтөлбөр". Энэ нь компьютерийн ухааны суурь агуулгаас гадна багшийн боловсрол олгодог хөтөлбөр. Гол онцлог нь COOP 101 (Мэдээллийн технологийн мэргэжлийн дадлага) болон PHIL 311 (IT-ийн ёс зүй), CIVC 101 (Иргэний оролцоо) гэсэн нийгмийн хариуцлагын хичээлүүд байна. Төгсөгч нь "инженер"-ийн бодит туршлагатай, нийгмийн идэвхтэй багш болдог.

- Mercer University (АНУ): "Багшийн хөтөлбөр". Энэ нь компьютерын ухаан (CSC, IST)-ны суурьтай. Гэвч Drexel-ээс ялгаатай нь "Мэдээлэл зүйг хэрхэн заах вэ?" гэдэг арга зүйг нарийвчилсан байдлаар судалдаг. Гол онцлог нь компьютерийн ухааны суурь, арга зүй, үнэлгээ гэж гурван агуулгыг судлана. Мөн түүнчлэн тэгш хамруулах боловсролын агуулгыг оруулсан байдаг.
- Dresden Technical University (Герман): "Академик (онолын) хөтөлбөр" Оюутан "Мэдээлэл зүй" болон "Математик" (эсвэл "Физик") гэсэн хоёр үндсэн мэргэжлийг ижил түвшинд гүнзгий судалж, дээр нь арга зүй хичээл үздэг. Өөрөөр хэлбэл, онолын суурьтай, академик мэргэжилтэн бэлтгэдэг.

Хүснэгт 5. Хөтөлбөрийн агуулгын харьцуулалт

Харьцуулах чиглэл	МУБИС-ийн “Багш, мэдээлэл зүйн боловсрол” бакалаврын хөтөлбөр	Олон улсын хөтөлбөр (Drexel, Mercer, Дрездений ИС) “Багш, компьютерын ухаан” бакалаврын хөтөлбөр
Ерөнхий суурь	Ёс зүйн ойлголт М.ИТ424-ийн хичээлийн агуулгад туссан байна	Ёс зүй: Бие даасан хичээлүүд (Drexel: PHIL 311 - ИТ-ийн ёс зүй; CIVC 101 - Иргэний оролцоо; Mercer: EDF3006).
Компьютерын ухаан Мэргэжлийн суурь (CS Core)	<ul style="list-style-type: none"> <li>• М.ИТ401 (Компьютерын үндэс)</li> <li>• М.ИТ402 (Програмчлалын хэл-1)</li> <li>• М.МВ303 (Алгоритм)</li> <li>• М.ИТ405 (Компьютерийн архитектур)</li> <li>• М.ИТ430 (Сүлжээний програмчлал)</li> <li>• М.ИТ412 (Кибер аюулгүй байдал)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• CSC 125 (Тооцоолол)</li> <li>• CSC 204 (Програмчлал 1)</li> <li>• CSC 148 (Өгөгдлийн бүтэц)</li> <li>• IST 222 (Үйлдлийн систем)</li> <li>• IST 221 (Сүлжээ)</li> <li>• SYS 223 (Кибер аюулгүй байдлын үндэс)</li> </ul>
Компьютерын ухаан Мэргэшүүлэх (Applied Tech)	<ul style="list-style-type: none"> <li>• М.ИТ415 (Хиймэл оюун)</li> <li>• М.ИТ429 (Мобайл программчлал)</li> <li>• М.ИТ425 (Интернэт программчлал - PHP)</li> </ul>	"Сонгон" хичээл эсвэл тусдаа мэргэшил болдог
Дидактик	<ul style="list-style-type: none"> <li>• М.ИТ316 (Багшлах арга зүйн технологи ба инноваци)</li> <li>• "Багш" мэргэжлийн бусад суурь хичээлүүд</li> </ul>	<p>Агуулга нь уялдаа холбоотой хичээлүүдэд туссан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Mercer: EDUC 443 (CS-ийн суурь), EDUC 444 (CS-ийн арга зүй), EDUC 445 (CS-ийн үнэлгээ) гэж 3-н тусдаа хичээл болгон задалсан.</li> <li>• Drexel/Monash/Дрезден: EDUC 283 / EDF2005 (Тусгай боловсрол), PSY 320 (Боловсролын сэтгэл зүй), EDUC 365 (Англи хэлгүй суралцагчдад заах) зэрэг тусгайлсан хичээлүүдтэй.</li> </ul>
Мэргэжлийн дадлага	Багшлах дадлага	<p>Хоёр төрлийн дадлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшлах дадлага: Маш эрчимтэй, үе шаттай (Mercer: EDUC 391 + EDUC 492; Drexel: EDUC 409 - 9 кредит).</li> <li>• Технологийн/ програмчлалын дадлага: Drexel: COOP 101 (IT компанид ажиллах дадлага).</li> </ul>

1. Ерөнхий суурь хичээлийн ялгааны хувьд ёс зүйн ойлголтыг Drexel-ийн PHIL 311 (ИТ-ийн ёс зүй) болон CIVC 101 (Иргэний оролцоо) зэрэг хичээлүүд нь "Технологийн нийгэмд үзүүлэх нөлөө, хариуцлага"-ыг бие даасан хичээл болгон үздэг бол


МУБИС-ийн хөтөлбөрт энэ нь тусдаа хичээл биш, M.IT424-ийн хичээлийн нэг хэсэг болсон бөгөөд багшийн ёс зүй гэсэн бие даасан хичээлийг сонгон хэлбэрээр судлахаар байна.

2. Мэргэжлийн суурь (CS Core) ижил байна. Mercer-ийн CSC/IST хичээлүүд нь МУБИС-ийн хөтөлбөрийн M.IT/M.MB суурь хичээлүүдтэй (Програмчлал, Архитектур, Сүлжээ, Аюулгүй байдал, Алгоритм) бараг 1:1 дүйцэж байна.
3. Мэргэшүүлэх (Applied Tech) хичээлийн ялгаатай байдал: МУБИС-ийн хөтөлбөр нь AI, Мобайл, PHP, Мультимедиа зэрэг орчин үеийн, програмчлалын технологиудыг багтааж байна. Энэ нь төгсөгчийг зах зээлд илүү уян хатан, өргөн мэдлэгтэй болгох давуу талтай.
4. Дидактикийн (Pedagogy) хичээлийн ялгаатай байдал: Олон улсын хөтөлбөрүүд "Мэдээлэл зүй"-г заах арга зүйг зөвхөн нэг хичээлийн агуулгаар хязгаарлахгүй, харин Mercer (EDUC 443, 444, 445) агуулгын хувьд уялдаатай хэд хэдэн хичээл болгон судлаж байна. Хэдийгээр МУБИС-ийн хөтөлбөрийн зорилго, боловсролын зорилтод суралцагчийн нас, сэтгэл зүйн ялгаатай байдал, соёлын ялгааг ойлгох, хүндэтгэх, сургалтын үйл ажиллагаанд харгалзахтай холбоотой агуулга тусгагдсан хэдий ч "Тусгай хэрэгцээт боловсролын үндэс" хичээлийг заавал судлахаар, Тусгай хэрэгцээт боловсролын сэтгэл судлал" хичээлийг сонгон судлахаар тусгасан.
5. Дадлага.
  - Хос дадлага: Drexel-ийн COOP 101 (Үйлдвэрлэлийн дадлага) нь оюутныг багшлах дадлагаас гадна IT компанид ажиллах бодит туршлага хуримтлуулж байна. Энэ нь төгсөгчийг хөдөлмөрийн зах зээлд "багш"-аар ч, "инженер" -ээр ч ажиллах боломжийг олгож байна. МУБИС-ийн хөтөлбөрт энэ боломж хязгаарлагдмал байна.

Судалгаанд сонгогдсон их сургуулиудын (Monash university, Nanjing Normal university, Old Dominion university, Colorado State University, Drexel University, Mercer University, University of Illinois University, Dresden University of Technology) сургалтын төлөвлөгөөг харьцуулахдаа хичээлийн бүлэг, заавал, сонгон судлах, багц цаг, судлах улирал гэсэн үзүүлэлтээр судалгааны мэдээлэл цуглуулав.

Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн агуулгын бүлгийг Зураг 3-т харуулав.

*Зураг 3. Сургалтын төлөвлөгөөний агуулга*



Дээрх зураглалаас харахад, хөтөлбөр хэрэгжүүлэгч их сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд компьютерийн ухааны хичээл - 36.8, боловсрол судлал – 12.5 хувь, математик – 8.3 хувь, нийгэм, хүмүүнлэг - 8 хувь, байгалийн ухаан – 2.0 хувь, дадлага – 4.0 хувь, гадаад хэл - 3,19 хувь, эх хэл - 2 хувь, арга зүй - 4.0 хувь, сэтгэл судлал - 2.2 хувь, физик - 1,7 хувь, СААЗ - 1,2 хувь, төсөлт, дипломын ажил - 1 хувийг тус тус эзэлж байна.

Дүгнэлт: Судалгааны хамрагдсан их сургуулиудын хөтөлбөрийн агуулга нь МУБИС-ийн мэдээлэл зүйн багшийн хөтөлбөрийн агуулгатай дүйцэж байна. МУБИС-ийн хөтөлбөр нь агуулгын хувьд өргөн хүрээтэй бөгөөд суурь мэдлэгийн хувьд олон улсын жишигт нийцэж байна. Харин олон улсын хөтөлбөрүүдээс суралцаж болох гол зүйл бол "Мэдээллийн технологийн ёс зүй"-г бие даасан хичээл болгох, "Мэргэжлийн заах арга зүй"-г илүү гүнзгийрүүлэн оруулах, тэгш хамруулах боловсролын агуулгыг бие даасан хичээлээр бус бусад хичээлийн агуулгад интеграц байдлаар оруулах, мөн "Мэдээллийн технологийн мэргэжлийн дадлага" (COOP загвар)-ыг нэвтрүүлэх явдал юм.

### МУБИС-ИЙН “ БАГШ, МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ

Дээрх харьцуулалтад үндэслэн, МУБИС-ийн хөтөлбөрийн "Багш" бэлтгэдэг суурь болон "Орчин үеийн технологи" заадаг давуу тал дээр нь тулгуурлан дараах зүйлийг санал болгож байна:

#### Санал 1: Мэдээлэл зүйн арга зүйг гүнзгийрүүлэх (Мерсер-ийн жишээ)

- Асуудал: М.ИТ316 (Багшлах арга зүйн технологи ба инноваци) хичээл нь "Мэдээлэл зүй"-г К-12-т хэрхэн заах талаарх бүх агуулгыг багтаахад хүрэлцээгүй байж болзошгүй.

- Санал: M.IT316 хичээлийг Mercer-ийн загвар (EDUC 443/444/445)-аар задлаж, дараалсан 2-3 хичээл болгох.
  1. "Тооцооллын сэтгэлгээ ба сургалтын үндэс": Компьютерын ухаан багшийн стандарт K-12-т "Тооцооллын сэтгэлгээ"-г хэрхэн заах, Алгоритм, Програмчлалын суурь ойлголтыг бага ангиас нь эхлэн хэрхэн таниулах гэж туссан байгаа.
  2. "Мэдээлэл зүйн хичээлийн арга зүй ба төлөвлөлт": Дунд, ахлах ангид сүлжээ, өгөгдлийн сан, кибер аюулгүй байдал зэргийг хэрхэн заах, хичээлийн хөтөлбөр боловсруулах.
  3. "Мэдээлэл зүйн сургалтын үнэлгээ": Код бичих, төсөл хийх зэрэг ур чадварт суурилсан ажлыг хэрхэн зөв. оновчтой үнэлэх (assessment).

### **Санал 2: "Мэдээллийн технологийн ёс зүй ба нийгэм" бие даасан хичээл нэвтрүүлэх (Drexel-ийн жишээ)**

- Асуудал: "Ёс зүй" нь M.IT424 (Криптограф)-ын тайлбарт зөвхөн дурдагдсан байна. Энэ нь орчин үеийн AI, data privacy (өгөгдлийн нууцлал), fake news (хуурамч мэдээлэл)-ийн эринд хангалтгүй юм.
- Санал: PHIL 311 (Drexel) шиг "Мэдээллийн технологийн ес зүй ба нийгэм" 3 кредитэй хичээлийг заавал судлах хичээл бий болгох. Энэ хичээлийг үзсэн багш сурагчдад зөвхөн "команд бичих" заах биш, "Дижитал Иргэншил" (Digital Citizenship), "Өгөгдлийн нууцлалаа хэрхэн хамгаалах", "Хиймэл оюуны нийгэмд үзүүлэх нөлөө" зэрэг чухал сэдвүүдээр ярилцаж, тэднийг бэлтгэж чадна.

### **Санал 3: "Хос дадлага"-ын нэвтрүүлэх (Drexel-ийн жишээ)**

- Асуудал: "Багшлах дадлага" хийсэн багш сургуулийн орчныг мэддэг ч, мэдээллийн технологийн зах зээлийг сайн мэддэггүй. "Зөвхөн онол заадаг" гэсэн шүүмжлэлд өртдөг.
- Санал: Оюутнууд "Багшлах дадлага"-аас гадна зуны амралтаар эсвэл нэг улирлын турш мэдээллийн технологийн компанид "үйлдвэрийн дадлага" (Internship/Co-op) хийхэд болох. Энэ дадлагыг хийснээр, багш сурагчиддаа "Би энэ кодыг компанид ингэж ашиглаж байсан...", "Зах зээл дээр ийм технологи эрэлттэй байгаа..." гэж бодит туршлагаас хуваалцаж, тэднийг "Мэргэжил сонголт"-д нь бодитоор чиглүүлж чадна.

### **Санал 4: Ялгаатай болон хүртээмжтэй компьютерийн ухааны сургалтын агуулгыг тусгах**

- Асуудал:

- МУБИС-ийн хөтөлбөрт тэгш хамруулах боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, соёлын агуулга нь зөвхөн нэг, нэг хичээлээр олгогдохоор төлөвлөгдсөн байна.
- Ангид суралцах хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн ялгаа, түвшин харилцан адилгүй байх боломжтой (суралцахуйн төрөл бүрийн бэрхшээл, хөгжлийн төрөл бүрийн бэрхшээл гэх мэт).
- Санал: Mercedes-ийн EDUC 283 (Тусгай боловсрол) шиг хичээлийг нэвтрүүлэх, эсвэл санал 1-д дурдсан арга зүйн хичээлүүдэд ялгаатай болон хүртээмжтэй компьютерийн ухааны сургалтын агуулгыг шингээх. Багш нар ангийнхаа сурагч бүрийг "орхигдуулахгүй", тус бүрийнх нь онцлогт тохирсон (жишээ нь, заримд нь визуал програмчлал, заримд нь текст, заримд сонсох хэрэглэгдэхүүнтэй ажиллах) аргаар мэдээлэл зүйг заах чадвартай болно. Мөн судалгааны арга зүй, үнэлгээний арга зүй, гадаад хэл, бүтээлийн хуулбарлалт, хэвлэл мэдээллийн боловсролын агуулгыг хэд хэдэн хичээлээр интеграц байдлаар хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх.

#### **Санал 5: Онол ба хэрэглээний тэнцвэрийг хангах (Dresden ба МУБИС-ийн жишээ)**

- Асуудал: МУБИС-ийн хөтөлбөр PHP, Мобайл зэрэг программчлалын технологид (Applied Tech) их анхаарсан нь давуу тал боловч технологи хурдацтай хуучирдаг.
- Санал: Германы (Dresden) хөтөлбөрт компьютерын ухааны онолын суурь (Algorithm, Logic, Data Structure, Architecture) хичээлүүд түлхүү, олон цагаар орж байна. МУБИС-ийн хөтөлбөрт M.MB303 (Алгоритм), M.MB304 (Логик), M.IT405 (Архитектур) зэрэг хичээлүүд байгаа боловч, ордог цагийн хувьд бага. Эдгээр онолын суурь хичээлүүдээс гадна AI, Мобайл хөгжүүлэлт зэрэг хэрэглээний хичээлүүд орж байна. Компьютерын ухааны онолын суурь хичээлүүдийн цагийг нэмэх, учир нь PHP програмчлалын хэл хуучирч болно, харин Алгоритмын онол хэзээ ч хуучрахгүй.

#### **Санал 6. Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийн хоорондын уялдаа холбоог ханган боловсруулах**

- Асуудал: Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн 1 хичээлээр хэрэгжиж байхад 15 хичээлээр 69 суралцахуйн үр дүн хэрэгжихээр тусгагдсан байна. Тухайлбал, Математик анализ-1, Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй, Суралцахуй ба багшлахуйн үндэс, Онлайн сургалтын аргазүй, Сургууль судлал, Шугаман алгебр, аналитик геометр-1, Сургалтын онол, арга зүй зэрэг мэргэжлийн суурь хичээлүүд нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн 30 орчим хувьд хамаарч байгаа бөгөөд нийт багц цагийн 12.8 хувийг эзэлж байна.
- Санал: Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар, чадамжийн хүрээнд үндэслэн эзэмших мэдлэг, ур чадвар хандлагыг эзэмшүүлэхэд хичээл бүр ямар үүрэг, оролцоотой байхыг том зургаар нь боловсруулахдаа багш нар нягт хамтарч ажиллах.

## Санал 7. “Багш, мэдээлэл зүйн боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг хөдөлмөрийн зах зээлд ажиллах ажлын байрны боломжийг илүү өргөн хүрээнд харж томъёолох

- Асуудал: “Багш, мэдээлэл зүйн боловсрол” хөтөлбөрөөр элсэгчийн тоо буурсан, зарим их сургуулиуд хөтөлбөрөө хаасан.
- Санал: “Багш, мэдээлэл зүйн боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн ажлын байрны боломжийг өргөн утгаар харах. Судалгаанд хамрагдсан сургуулиудын төгсөгч нь компьютерийн ухааны багш (бага боловсрол, суурь, бүрэн дундын боловсролын түвшинд ялгаатай бэлтгэх), судлаач, мэргэжлээрээ хөрвөн ажиллах боломжтой байхаар бэлтгэж буй туршлагыг хэрэгжүүлэх.

### Ном зүй

- INNOTECH, S. (2018). *Southeast Asia Teachers Competency Framework (SEA-TCF)*.  
<https://www.seameo-innotech.org/>: [https://www.seameo-innotech.org/wp-content/uploads/2020/09/SEA-TCF\\_2018.pdf](https://www.seameo-innotech.org/wp-content/uploads/2020/09/SEA-TCF_2018.pdf)
- OECD. (2018). *The Future of Education and Skills: Education 2030*. Paris.
- Standards for CS Teachers Downloads*. (2025). <https://csteachers.org/>:  
<https://csteachers.org/teacherstandards/downloads/>
- Technology, D. U. (2025). *Computer Science (Teaching subject middle schools, state examination)*.  
<https://tu-dresden.de/>: [https://tu-dresden.de/studium/vor-dem-studium/studienangebot/sins/sins\\_studiengang?autoid=5005](https://tu-dresden.de/studium/vor-dem-studium/studienangebot/sins/sins_studiengang?autoid=5005)
- UNESCO. (2019). *Global Framework of Professional Teaching Standards*. Brussels, Belgium: UNESCO.
- БСҮХ. (2022). *“Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн чадамжийн хүрээг тодорхойлох судалгааны тайлан*. Улаанбаатар: БСҮХ.
- БШУЯ. (2021). *Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030*.  
<https://cdn.greensoft.mn/>:  
<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/PDF%20files/Development%20plan%202030%20Mon.pdf>
- БЯ. (2020). *Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага*. [www.moe.gov.mn](http://www.moe.gov.mn) :  
<https://moe.gov.mn/post/67947>
- БЯ. (2025). [esis.edu.mn](https://www.esis.edu.mn/): <https://www.esis.edu.mn/hr/index.html#/>
- Засгийн газар, (2024). *Үзэл баримтлал батлах тухай*. <https://legalinfo.mn/>:  
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>

МУЗГ. (2022). *Журамд өөрчлөлт оруулах тухай*. <https://legalinfo.mn/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530790607241>

МУИХ. (2018). *Багшийн хөгжлийн дэмжих тухай хууль*. <https://legalinfo.mn/https://legalinfo.mn/mn/detail/13532>

МУИХ. (2020). *"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. <https://legalinfo.mn/https://legalinfo.mn/mn/detail/15406>

**Гадаадын их сургуулиудын хөтөлбөрийн талаарх холбоос:**

- [https://tu-dresden.de/studium/vor-dem-studium/studienangebot/sins/sins\\_studiengang?autoid=5005#study\\_con](https://tu-dresden.de/studium/vor-dem-studium/studienangebot/sins/sins_studiengang?autoid=5005#study_con)
- <https://catalog.drexel.edu/undergraduate/schoolofeducation/teachereducation/computer-science/>
- <https://catalog.drexel.edu/undergraduate/schoolofeducation/teachereducation/computer-science/#sampleplanofstudytext>
- <https://education.mercer.edu/academic-programs/initial-teacher-certification/b-s-ed-in-computer-science-education/>
- <https://catalog.colostate.edu/general-catalog/colleges/natural-sciences/computer-science/computer-science-major/computer-science-education-concentration/#requirementstext>
- <https://catalog.illinois.edu/undergraduate/education/computer-science-education-bs/secondary-education/#degreerequirementstext>
- <https://www3.monash.edu/pubs/2008handbooks/courses/3725.html>
- <https://catalog.odu.edu/undergraduate/sciences/computer-science/computer-science-secondary-education-6-12-bscs/#requirementstext>
- <https://en.njnu.edu.cn/academics/computer-science-and-technology-teacher-education>

*ХАВСРАЛТ. Гадаадын их сургуулиудын сургалтын төлөвлөгөөний агуулга*

Хич.код	Хичээлийн нэр	Судлах хэлбэр	Судлах улирал	Course description	Сургууль
INF-SEOS-INF-01	Мэдээлэл зүйн үндэс	Заавал	өвлийн улирал	МС ойлголт, өгөгдөл хадгалах болон дамжуулах, компьютерын бүтэц, програмчлалын суурь ойлголт, веб программчлал (HTML, CSS, JS) , интернэт сүлжээ, өгөдлийн сан, мэдээлэл зүйн онолын суурь ойлголт	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-02	Дээд тоо	Заавал	өвлийн улирал	Шугаман алгебра	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-03	Программчлал	Заавал	зуны улирал	Алгоритм, программчлалын үндэс, объект хандалтын программчлалын үндэс	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-04	Мэдээлэл зүйн заах арга зүйн үндэс	Заавал	зуны улирал	Хичээл төлөвлөлт ба хичээл зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр ба сургалтын стандарт, суралцахуйн зорилт, МХХТ-ийг сургалтад ашиглах, сургуулиудын төрөл ба онцлог	Дрездены Техникийн Их Сургууль

INF-SEOS-INF-05	Хүн ба компьютерын харилцаа	Заавал	өвлийн улирал	Хэрэглэгч төвтэй дизайн, хүн ба компьютерийн харилцаа, даалгаврын шинжилгээ, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, технологи сонгох, интерфэйсийн дизайн, төхөөрөмжтэй харилцан үйлчлэх арга, хэрэглэгчийн интерфэйс, хэрэглэгчийн интерфэйсийг үнэлэх аргачлал, эвристик ба эмпирик шинжилгээ.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-06	Техникийн үндэс	Заавал	өвлийн улирал	Компьютерын дизайн болон архитектур, Программчлалын доод түвшны хэл ассамблер	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-07	Мэдээлэл зүйг заах арга зүй	Заавал	зуны улирал	Сургалтын хөтөлбөр ба бүтэц нь, КУ шинжлэх ухааныг нотолгоонд суурилсан сургалтын загварчлал, хичээл зохион байгуулах ба төлөвлөх, КУ хичээлийг заах арга зүй, цахим хэрэглэгдэхүүн, нээлттэй боловсролын нөөц, сурагчдыг үнэлэх арга зүй, сурагч бүрийг дэмжсэн бие даан ажиллах дасгал, хичээлийн агуулгын интеграци.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-08	Компьютерын сүлжээ	Заавал	зуны улирал	Сүлжээний ойлголт, хэрэгцээ, үүрэг, сүлжээний протокол, Интернэт сүлжээ, компьютерын сүлжээг тохируулах, судлах программ хангамж	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-09	Программчлал -2	Заавал	өвлийн улирал	Асуудал шийдвэрлэх үйл явцыг загварчлах, императив, функциональ, логик болон объект хандалтат програмчлалын парадигм, асинхрон асуудлуудын шийдэл (өгөгдлийн сангийн холболт өгөгдөл, үйлчлүүлэгч-сервер, вэб контент), гадны өгөгдлийн сантай холболт дүн шинжилгээ хийх, ашиглах.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-10	Мэдээллийн технологийн ба нийгэм	Заавал	өвлийн улирал	Мэдээллийн технологи хэргэлж нийгмийн өөрчлөлтийг үнэлэх, болон эрсдэл, боломжийг тооцдог болох. Мэдээллийн технологитой холбоотой хууль эрх зүйн баримт бичигтэй ажиллах. Мэдээллийн систем нэвтрүүлсэнтэй үүдэлтэй хэрэглэгчийн үйл ажиллагаанд нөлөөлж буй байдал болон бэрхшээлийг мэддэг болно. Мэдээллийн аюулгүй байдал болон нийгэмд үзүүлэх гарч болох мэдээллийн аюулгүй байдал алдагдах тохиолдолд гарч болох сөрөг нөлөөг судлана.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-11	Өгөгдлийн сан ба мэдээллийн систем	Заавал	зуны улирал	Өгөгдлийн загварчлалыг ашиглан мэдээллийн системийг хөгжүүлэх.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-15	Программ хангамж	Заавал	зуны улирал	Програм хангамжийн хөгжүүлэх арга барилд суралцана мөн объект хандалтат загварчлал, дүн шинжилгээ хийх, дизайн хийх, програмчлал.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-16	Заах арга зүйн технологи	заавал	зуны улирал	Боловсролын технологийг хөгжүүлэхдээ дизайн хийх, загварчлах. Үүнийг дидактик, сэтгэл судлал, мэдээллийн технологи болон бусад салбаруудын үндсэн загварыг интегралчилаж боловсруулна.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-19	Дунд сургуульд мэдээлэл зүй заах арга зүй	заавал	өвлийн улирал	ЕБС-ийн мэдээлэл зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгын шинжилгээ хийх. Компьютерийн шинжлэх ухааны дидактикийн үндсэн асуудлууд, чиглэлүүдийг ялгаж, практикт хэрэглэх. Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн шинжлэх ухааны боловсролыг дэмжих дижитал хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг судлах. Мэдээлэл зүй заах арга зүйд өөрийн хувь нэмэр оруулах. Мэдээлэл зүйг заах арга зүйн шинэ ололт, судалгаа шинжилгээтэй танилцах.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-21	Дадлага / танилцах/	заавал	өвлийн улирал	Сургууль дээр мэдээлэл зүйн хичээлийг дадлага хийх ажлын төлөвлөгөө гаргах, хичээлээ төлөвлөх, заах, үнэлэх. Хичээлийн агуулдгша болон суралцагчдын онцлог нийцсэн саралцах арга барил хэрэглэх.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-22	Дадлага	заавал	Улирал болгон	Сургалтын томоохон сэдвүүдийг бие даан төлөвлөх (суралцах чиглэлүүд). Арга зүйн зохион байгуулах ур чадвартай, заах арга зүй, төлөвлөлт болон бие даасан байдлаар хичээл зохион байгуулах хооронд нь холбох чадвартай байж тодорхой хэдэн сэдвээр хичээл зохион байгуулах.	Дрездены Техникийн Их Сургууль

INF-SEOS-INF-17	Программ хангамжийн төсөл	сонгон	өвлийн улирал	Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоод программ хангамж хөгжүүлэх төсөл боловсуулж хөгжүүлэх, тестлах, нэвтрүүлнэ.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-18	Заах арга зүйн төсөл	сонгон	өвлийн улирал	Мэдээллийн технологи, сэтгэл зүй, дидактик талыг харгалзан дижитал боловсролын программ хангамж дизайныг гаргаж багаар хөгжүүлнэ.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-20b	Веб технологи ба мультимедиа	сонгон	өвлийн улирал	Мультимедиа, интерактив вэб программуудыг хөгжүүлэх арга, хөгжүүлэх үзэл баримтлал, архитектурын зарчим, хөгжүүлэлтийн хэрэгслүүдтэй танилцах болно. Асуудалд тохирох шийдлийн арга, арга, хэрэгслийг тодорхойлох чадвартай болно.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-20c	График дизайны үндэс	сонгон	өвлийн улирал	График программчлалын үндсэн ойлголттой болно. Загварчлах, дүрслэх, хөдөлгөөнт дүрслэх программчлалтай танилцаж, холболт үүсгэх чадвартай. Асуудалд тохирох геометрийн дүрслэлийг санал болгох, геометрийн загварчлалын үндсэн алгоритмуудыг хэрэглэх чадвартай болно. График программчлалаар хөдөлгөөнт дүрс /анимаци/ хөгжүүлэх боломжтой болно.	Дрездены Техникийн Их Сургууль
INF-SEOS-INF-20f	Дипломны ажил	сонгон	өвлийн улирал	Судалгааны ажил хийх арга зүй, өгүүлэл, сулалгааны ажил бичих, танилцуулах, мэтгэлцэх чадвартай болно.	Дрездены Техникийн Их Сургууль
CIVC 101	Иргэний оролцоо	Заавал		Хариуцлагатай, нийгмийн ухамсартай иргэн байх нь юу гэсэн үг болохыг судлах. Иргэний оролцоо тодорхойлолтыг судалж, нийгмийн асуудлыг илүү сайн ойлгох, иргэний оролцоогоор дамжуулан нийгмийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх үндсийг тавихын тулд хувийн шинж чанар, олон нийт, тогтолцооны ойлголтуудыг харьцуулж судлах. Олон нийтийн оролцоотой холбоотой сургалтын хичээлийн хувьд оюутнууд танхимын сургалтаас гадна сайн дурын ажил болон бусад олон нийтийн ажил гүйцэтгэх. Хичээлийн туршид оюутнууд суралцах, оролцоогоо холбохын тулд эргэцүүлэн бодох үйл ажиллагаанд оролцож хичээлээс гадна мэдлэг, дадлагаа ахиулна.	AHU, Drexel university
COOP 101	Мэргэжлийн хөгжил	Заавал		Ажил мэргэжлийн чиг баримжаа, анкет бөглөх, ярилцлагад оролцох арга техник, ажил хайх стратеги, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн ур чадвар зэрэг сэдвүүд багтана.	AHU, Drexel university
ECON 201	Микроэкономик	Заавал		Эдийн засгийн ойлголт. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл. Зах зээл зарчим. Хэрэглэгчид болон үйлдэрлэгчдийн зан төлөв, эдийн засгийн сэтгэлгээ. Бодлого, эмпирик хэрэглээг онцолсон эдийн засаг, микро эдийн засгийн онол. Хэрэглэгчид, бизнес эрхлэгчид, бодлого боловсруулагчид амжилттай шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой эдийн засгийн ур чадвар, практик мэдлэгийг хөгжүүлэх болно.	AHU, Drexel university
ENGL 101	Бичих болон илтгэх ур чадвар	Заавал		Зөв бичих болон илтгэх чадварыг хөгжүүлдэг. Төрөл бүрийн онол, бичих, хянан засварлах. Зөв бичих дүрэм, баримт бичгийн дүрмийг судалдаг.	AHU, Drexel university
ENGL 111	Англи хэлний найруулга I	Эсвэл ENGL 101 сонгох		Нийгэм, улс төр, боловсролын нээлттэй асуудлуудыг судлах явцдаа шүүмжлэлтэй үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийг өөрийн эссэ, зохион бичлэгт нэгтгэх чадварыг хөгжүүлдэг. Зөв бичих дүрэм, баримт бичиг боловсруулах арга зүйг үргэлжлүүлэн суралцах. Бичлэгт эерэг хандлагыг шингээсэн байдлаар боловсруулах арга зүйг суралцах.	AHU, Drexel university
ENGL 102	Бичих болон илтгэх ур чадвар II	Заавал		Асуудлуудыг судлах явцдаа харьцуулж үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийг өөрсдийн бичвэртээ нэгтгэх. Хэл яриа, нотлох баримт, баталгааны хэрэгцээ хоёрын хоорондын уялдаа холбоог тодорхойлох. Зөв бичгийн дүрэм, баримт бичгийн дүрмийг үргэлжлүүлэн суралцах. Интернэт болон номын сангийн эх сурвалжийг хайх, хамтран ажиллах чадвартай болох. Дүн шинжилгээ хийх, бичих эерэг хандлагыг дэмжих.	AHU, Drexel university
ENGL 112	Англи хэлний найруулга II	Эсвэл ENGL 102 сонгох		(Англи хэлээр ярьдаггүй) оюутнуудыг зөв бичих, эргэцүүлэн бодох хэрэгсэл болгон ашиглах чадварыг хөгжүүлэх. Нийгэм, улс төр, боловсролын нээлттэй асуудлуудыг судлах явцдаа шүүмжлэлтэй, дүгнэх, мэдээллийг эссэ болон зохион бичлэгтээ нэгтгэх чадварыг хөгжүүлдэг. Зөв бичих дүрэм, баримт бичиг боловсруулах, хянах чадвартай болгох. Судалгаа, шинжилгээний үр дүнг хамтарч ажиллах ур чадварыг хөгжүүлэх. Бичлэгт эерэг хандлагыг шингээх.	AHU, Drexel university

ENGL 103	Бичих болон илтгэх ур чадвар III			Бичих, судлах үйл явцыг хөгжүүлэх, бичих төрөл нь агуулга хэрхэн бүрдүүлдэг тухай ойлголтыг бий болгох. Эрдэм шинжилгээний болон сахилга баттай холбоотой туршлагад анхаарлаа хандуулах; уран зохиолын болон нийгмийн сэдэв дээр үндэслэсэн байж болох. Текстийг шүүмжлэлтэй унших, эргэцүүлэн бодох дүн шинжилгээ хийх, бичихэд эерэг хандлагыг дэмжих.	AHU, Drexel university
ENGL 113	Англи хэлний найруулга II	Эсвэл ENGL 103 сонгох		(Англи хэлээр ярьдаггүй) оюутнуудыг зөв бичих, эргэцүүлэн бодох хэрэгсэл болгон ашиглах чадварыг хөгжүүлэх. Эрдэм шинжилгээний болон сахилга баттай холбоотой туршлагад анхаарлаа хандуулах; уран зохиолын болон нийгмийн сэдэв дээр үндэслэсэн байж болох. Текстийг шүүмжлэлтэй унших, эргэцүүлэн бодох, дүн шинжилгээ хийх, бичихэд эерэг хандлагыг дэмждэг.	AHU, Drexel university
HIST 285	Түүх ба ирээдүйн хөгжил	заавал		Технологийн хөгжил болон 18-р зуунаас өнөөг хүртэлх барууны соёл иргэншлийн эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, улс төрийн талуудын хоорондын учир шалтгааны хамаарлыг судлана	AHU, Drexel university
MATH 121	Математик 1	заавал		Функц, хязгаар ба тасралтгүй байдал, дериватив, трансцендент функц ба хэрэглээ.	AHU, Drexel university
MATH 122	Математик 2	заавал		Интеграл, тооцооллын үндсэн теорем, интегралчлалын арга, интегралын хэрэглээ, тоон интеграл, дифференциал тэгшитгэл.	AHU, Drexel university
MATH 123	Математик 3	заавал		Дифференциал тэгшитгэл, Тейлорын теорем, дараалал ба цуваа.	AHU, Drexel university
MATH 221	Дискрет математик	заавал		Олонлогийн онол, комбинаторик, энгийн тооны онол, график, алгоритм, формаль хэлтусгай сэдвүүд.	AHU, Drexel university
MATH 311	Магадлалын онол ба статистик 1	заавал		Дискрет ба тасралтгүй магадлалын тархалт, нөхцөлт магадлал, хүлээгдэж буй утга ба дисперс, хамтарсан магадлалын тархалт.	AHU, Drexel university
MATH 410	Өгөгдлийн шинжилгээ	сонгох		Шинжлэх ухааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх статистикийн үндсэн зарчим, хэрэглээ. Өгөгдлийн шинжилгээ, магадлалын тархалтын зарчим, төвлөрсөн хязгаарын теорем, таамаглалыг шалгах, z-, t-, F-туршилтууд, ANOVA, шугаман регресс, болзошгүй байдлын хүснэгтийн шинжилгээ хийх. R хэл дээрх статистикийн программчлал	AHU, Drexel university
PHIL 311	Ес зүй ба мэдээллийн технологи	заавал		Компьютерын мөн интернетийн хэрэглээ, мэдээллийг ес зүйтээ хэрэглэх зохицуулалт, хууль тогтоомж.	AHU, Drexel university
PSY 101	Сэтгэл судлал	заавал		Сэтгэл судлалын үндсэн зарчим, үзэл баримтлал, аргууд. үндсэн ойлголт.	AHU, Drexel university
PSY 320	Боловсролын сэтгэл судлал	заавал		Багш сурагчдын харилцаанд сэтгэл судлалын үүрэг, ач холбогдол, судалгааны аргууд, дадлага.	AHU, Drexel university
UNIV T101	Drexel -ийн танилцуулга	заавал		Их сургуулийн амьдрал, тэдний мэргэжил, хамт олон, хамтын ажиллагааны талаар танилцуулдаг.	AHU, Drexel university
CI 120	Бакалаврын сургалтыг дэмжих семинар	сонгох эсвэл UNIV T101		Их сургуулийн амьдралын эрдэм шинжилгээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагаатай танилцуулдаг. Үүнд эргэцүүлэн бодох, суралцах ур чадвар зэрэг эрдэм шинжилгээний онцлогууд, мөн оюутны хотхоны нөөц, арга хэмжээ, нийгмийн хөтөлбөр зэрэг хичээлээс гадуурх онцлогуудыг танилцуулдаг. Drexel-ийн бакалаврын амьдралд шилжихэд тусалдаг бөгөөд оюутан тус бүрийн сурлага, ажил мэргэжлийн чиг баримжаа, эрдэм шинжилгээний болон хувийн амжилтанд хүрэхэд нь туслах зорилготой хичээл юм.	AHU, Drexel university
BIO 131	Биомолекул			Амьдралын хамгийн жижиг нэгж болох эс, эсүүд хэрхэн ажиллаж, үржиж шинэ эс, бэлгийн эсийг бий болгодог, эсүүд эд, эрхтэнд хэрхэн харилцан үйлчилдэг талаар анхан шатны ойлголтууд, эсийн мэдээллийг генийн илэрхийлэл, хадгалалт, удамшлын молекулын механизмтай танилцдаг.	AHU, Drexel university
BIO 134	Эс ба биомолекулын дадлага	Заавал BIO 131 дараа судлах		Амьдралын хамгийн жижиг нэгж болох эсийн тухай, эсүүд хэрхэн ажиллаж, үржиж, шинэ эс, бэлгийн эсийг үүсгэдэг, эсүүд бие биетэйгээ эд, эрхтнүүдтэй хэрхэн харьцдаг талаар үндсэн ойлголттой болохын тулд практик туршилт хийж, өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломжийг олгоно	AHU, Drexel university

BIO 132	Генетик ба хувьсал			Генетикийн удамшил (менделийн болон менделийн бус удамшлын хэв маяг), популяци, генетикийн өөрчлөгддөг механизмын талаар мэдэж, хувьслын гол шалтгаануудыг судлана. Мөн бие даасан организмын хөгжлийг судалж, хөгжлийн үйл явцыг хувьслын чиг хандлагатай холбох чадвартай болно	AHU, Drexel university
BIO 135	Генетик ба хувьсал хичээлийн лаборатори	Заавал BIO 132 дараа судлах		Генетик болон хувьслын үзэл баримтлалыг судлах, лабораторийн арга техникт суралцах. Өгөгдлийг тайлбарлах, шүүмжлэх сэтгэлгээ, шинжлэх ухааны ур чадвараа хөгжүүлэхийн зэрэгцээ генетикийн техникийг ашиглан туршилт хийх чадвартай болно. Компьютерын загварчлал, өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь оюутнуудад генетик өөрчлөлтийн үзэл баримтлалын талаархи ойлголтоо болох, бодит ертөнцийн өгөгдөлд ашиглах, шинжилгээ хийх чадвартай болно.	AHU, Drexel university
BIO 133	Физиологи ба экологи			Амьтдын амьсгал, цусны эргэлт, гомеостаз, ялгаруулах, хоол боловсруулах, дархлаа, нөхөн үржихүйн систем зэрэг физиологийн системийг судлах. Организм ба хүрээлэн буй орчны хоорондын харилцаа, экосистем, биосферт хэрхэн нөлөөлдөг талаар суралцах.	AHU, Drexel university
BIO 136	Анатоми, экологийн семенарын хичээл	Заавал BIO 133 дараа судлах		Амьтдын анатомийн системийг судлах, амьтад хүрээлэн буй орчноосоо хүчилтөрөгч болон бусад шим тэжээлийг олж авах, бие махбодид боловсруулах, гомеостазыг хадгалах, хог хаягдлыг цуглуулах, устгах арга замыг харьцуулах. Амьд организм ба тэдгээрийн хүрээлэн буй орчны хоорондын харилцааг онцлон харуулах болно. Энэ хичээлийн лабораторийн дасгалууд нь анатомийн системийг судлах, экологийн гол сэдвүүдийг харуулах, хүмүүс экосистемд хэрхэн нөлөөлж байгааг загварчлах..	AHU, Drexel university
CHEM 101	Хими 1			Хими, стехиометри, атом ба молекулын бүтэц, химийн элемент, бодисын найруулга, термохими, үечилсэн байдлын. химийн үндсэн зарчмуудыг судлах	AHU, Drexel university
CHEM 102	Хими 2			Уусмал дахь хүчил-суурь тэнцвэр, цахилгаан хими, органик хими, полимер, газрын тос зэрэг химийн элементуудыг судлана.	AHU, Drexel university
CHEM 103	Хими 3	CHEM 101, CHEM 102 дараа судлах		Биохими, органик бус ба зохицуулалтын нэгдлүүд, химийн кинетик, термодинамик ба цөмийн хими.	AHU, Drexel university
PHYS 101	Физик 1			Кинематик, инерци ба инерциал бус хүрээ, Ньютоны хөдөлгөөн, хүч, энерги, импульсийн хуулиуд. Эрчим хүч, импульс хадгалах тухай ойлголт. Эргэлтийн кинематик ба динамик.	AHU, Drexel university
PHYS 102	Физик 2			Цахилгаан ба соронзны хууль танилцуулах физикийн гурван курсын хоёр дахь хичээл. Сэдвүүд: Электростатик, Кулоны хууль, цахилгаан орон ба урсгал, Гауссын хууль. Цахилгаан потенциал ба потенциал энерги ба конденсатор. Хөдөлгөөний цэнэг, хүчдэл, гүйдлийн хэмжилт. Омын хууль ба Кирхгофын дүрмийг ашиглан шууд гүйдлийн хэлхээний шинжилгээ. Соронзон орны эх үүсвэр, соронзон урсгал ба цахилгаан соронзон индукцийн тухай ойлголт.	AHU, Drexel university
PHYS 201	Физик 3	PHYS 101, PHYS 102 дараа сулах хичээл		Долгион, харьцангуйн онол, квант механикийг танилцуулах физикийн гурав дахь нь хичээл. Сэдвүүд: Максвеллийн тэгшитгэл, цахилгаан соронзон долгион, цахилгаан соронзон долгионы интерференц ба дифракц. Харьцангуйн тусгай онолын танилцуулга. Де Бройлийн долгион-бөөмийн хоёрдмол байдлын таамаглал, Комптон сарнилт, Гейзенбергийн тодорхойгүй байдлын зарчим, Шредингерийн тэгшитгэл.	AHU, Drexel university
CS 150	Компьютерын шинжлэх ухааны үндэс		Заавал	Компьютерын шинжлэх ухааны ойлголт, тооцооллын сэтгэлгээ, компьютер, мэдээллийн технологийн нийгэмд үзүүлэх нөлөө. Програмчлалын ач холбогдлыг, алгоритм, их өгөгдөл, машин суралцах, нууцлал, аюулгүй байдал, дижитал иргэншил.	AHU, Drexel university
CS 175	Програмчлал I	эсвэл CS 150 оронд сонгох боломж	Заавал	Санах ой, зааварчилгаа, функцийн дуудлага, идэвхжүүлэлтийн бүртгэл зэрэг тооцооллын үндсэн ойлголтууд. Компьютерын програмчлалын үндэс: нөхцөл ба салаалалт, дэд программ, параметр дамжуулах, давталт, массив, дээрээс доош дизайн, туршилт, дибаг хийх.	AHU, Drexel university

CS 172	Програмчлал 2		Заавал	Объект хандалтат програмчлал, шатлал, мэдээллийг нуух зарчим, стринг боловсруулах, рекурс, програмчлалын хэв маяг, баримтжуулалт, дибаг хийх, тестлах.	AHU, Drexel university
CS 260	Өгөгдлийн бүтэц		Заавал	Өгөгдлийн бүтцийн үндэс суурь ойлголт. Хайх, эрэмбэлэх зэрэг нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд өгөгдлийн бүтцийг ашиглаж алгоритм боловсруулах, үүнд дараалсан, хосоор нь эсвэл шаталсан холбоотой өгөгдөл орно. Өгөгдлийг хийсвэрлэх, функциональ шаардлага, хамаарлын үүднээс авч үзэх зэрэгт суралцах болно. Оюутнуудын хийсвэр сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлнэ.	AHU, Drexel university
CS 265	Програмчлал ба техник хангамж		Заавал	Програмчлалын үндсэн зарчмууд: туршилт, дибаг хийх, зөөвөрлөх чадвар, гүйцэтгэл, дизайны хувилбарууд, хэв маяг. Төрөл бүрийн програмчлалын хэл, програмчлалын орчин, үйлдлийн системд хэрэглэх. Програм хангамжийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, програм хангамжийг сайжруулах явцад ашигладаг хэрэгслүүд.	AHU, Drexel university
CS 270	Тооцоолон бодох		Заавал	Компьютерын программуудын үйлдлийн логик үндэслэл болгон хөрвүүлэх, уламжлалт арга техник болон автоматжуулсан хэрэгслүүдийг ашиглан нотлоход суралцдаг. Хийсэн үйлдлийн зөв эсэх, аюулгүй байдлыг батлах арга барилтай болно. Санал ба предикатын логик, логик дүгнэлт, рекурс ба рекурсив тодорхойлогдсон олонлогууд, математик индукц, бүтцийн индукци.	AHU, Drexel university
CS 375	Веб хөгжүүлэлт		Заавал	Вэб хөгжүүлэлт. HTML, CSS болон клиент талын JavaScript, вэб сервер, өгөгдлийн сан.	AHU, Drexel university
CS 277	Алгоритм ба шинжилгээ		Сонгон судлах	Тооцоолох, шийдвэр гаргах чадвар, Тьюрингийн машин, алгоритмын зэрэг Компьютерийн шинжлэх ухааны онолын үндсэн ойлголтууд. Онол ба практикийн хооронд контекст холболтыг бий болгохын тулд график онол, автоматын үндсэн ойлголтуудыг тооцоолоход ашиглах	AHU, Drexel university
CS 281	Системийн Архитектур		Сонгон судлах	Оролт-гаралтын архитектур, төв процессорын зохион байгуулалт, машины хэл, ассемблер хэл зэрэг дижитал компьютерийн дотоод функц, зохион байгуулалт	AHU, Drexel university
SE 181	Програм хангамжийн инженерчлэл ба хөгжүүлэлт		Сонгон судлах	Санах ой удирдлага, мэдээлэл оруулах, өгөгдлийн сан, програм хангамжийн туршилт, аюулгүй байдал, мөн хэрэглэгч төвтэй дизайн зэрэг програм хангамж хөгжүүлэх үндэс	AHU, Drexel university
CI 101	Тооцоолол ба мэдээлэл зүйн дизайн I			Тооцоолол, мэдээлэл зүйг лекц болон практик лабораторийн дасгалуудыг хослуулан хэрэгжүүлнэ. Лекцүүд нь доод түвшний программ хангамжаас эхлээд өндөр түвшний хэрэглээ, хувь хүн, олон нийтийн хүлээн зөвшөөрөх хүртэлх хөгжүүлэлтийн асуудал, тогтолцооны нэгдсэн ойлголтой болно. Лабораторийн дасгал ажлаар суралцагчид эдгээр системийг хэрхэн зохион бүтээж, ашиглаж байгааг илүү сайн ойлгох, шинэ арга замаар танил системийг судлах боломжтой.	AHU, Drexel university
CI 102	Тооцоолол ба мэдээлэл зүйн дизайн II			Тооцоолол, мэдээлэл зүйг лекц болон практик лабораторийн дасгалуудыг хослуулан хэрэгжүүлнэ. Лекцүүд нь доод түвшний программ хангамжаас эхлээд өндөр түвшний хэрэглээ, хувь хүн, олон нийтийн хүлээн зөвшөөрөх хүртэлх хөгжүүлэлтийн асуудал, тогтолцооны нэгдсэн ойлголтой болно. Лабораторийн дасгал ажлаар суралцагчид эдгээр системийг хэрхэн зохион бүтээж, ашиглаж байгааг илүү сайн ойлгох, шинэ арга замаар танил системийг судлах боломжтой.	AHU, Drexel university
CI 103	Тооцоолол ба мэдээлэл зүйн дизайн III			Тооцоолол, мэдээлэл зүйг лекц болон практик лабораторийн дасгалуудыг хослуулан хэрэгжүүлнэ. Лекцүүд нь доод түвшний программ хангамжаас эхлээд өндөр түвшний хэрэглээ, хувь хүн, олон нийтийн хүлээн зөвшөөрөх хүртэлх хөгжүүлэлтийн асуудал, тогтолцооны нэгдсэн ойлголтой болно. Лабораторийн дасгал ажлаар суралцагчид эдгээр системийг хэрхэн зохион бүтээж, ашиглаж байгааг илүү сайн ойлгох, шинэ арга замаар танил системийг судлах боломжтой.	AHU, Drexel university
EDEX 142	Тусгай боловсролын үндэс: үндсэн ойлголт ба үнэлгээ			Тусгай боловсролын түүх, хууль эрх зүй, ёс зүйн үнэлгээний арга хэрэгсэл, салбар хоорондын хамарсан үнэлгээ (MDE) болон хувь хүний сургалтын хөтөлбөр (IEP), тусгай боловсролтой холбоотой хууль эрх зүйн чухал асуудлуудад анхаарал хандуулсан хөтөлбөр.	AHU, Drexel university

EDEX 344	Тэгш хамруулан сургах			Хүүхдийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшил, зан үйл, хэл ярианы олон талт хөгжлийг судлах замаар тэгш хамруулан сургах, сурагч бүрд зориулсан сургалтын менежментэд голлон анхаарч, сурагчдын хэрэгцээг хангахад сургалтын хөтөлбөр, хүрээлэн буй орчин, сургалтын дасан зохицох асуудлыг үзнэ.	AHU, Drexel university
EDEX 368	Бичиг үсэг, агуулгын ур чадварыг хөгжүүлэх РК-12			Бичиг үсэгт тайлагдаагүй, хоцрогдолд өртөх эрсдэлтэй оюутнууд болон бичиг үсэгт тайлагдсан оюутнуудын бичиг үсгийн чадварыг хөгжүүлэх. Оюутны код тайлах, кодлох, үгийн сан, чөлөөтэй ярих, ойлгох чадварыг сайжруулахад чиглэсэн.	AHU, Drexel university
EDLT 326	Сургалтын дижитал технологи			Цахим технологийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах сургалтын дизайн, боловсруулалт, хэрэгжилт, үнэлгээний үүднээс судалдаг. Хэрэглээний программуудыг сургалтад ашиглах, албан болон албан бус сургалтын төрөл бүрийн орчинд тоон технологиудыг нэгтгэх холбоотой асуудлуудыг шийдэх.	AHU, Drexel university
EDPO 312	Боловсролын бодлого			АНУ-ын улсын сургуулийг бүрдүүлдэг хууль тогтоомж, бодлогын талаар танилцах. Боловсролын хууль, бодлого нь багш нарын хувьсан өөрчлөгдөж буй үүрэг, харилцаа, практикт хэрхэн нөлөөлж байгааг судлах.	AHU, Drexel university
EDUC 101	Боловсролын түүх ба философи			Америкийн боловсролын түүх, боловсролын философийн үзэл баримтлал, онол, арга зүйг судлана.	AHU, Drexel university
EDUC 106	Эхний жилийн семинар: Сургууль ба хотуудын жишээ			Хотын сургууль, хотуудын хоорондын хамаарал, АНУ-ын томоохон хотод сургууль хаагдахад улс төр, арьсны өнгө, ядуурал зэрэг хэр нөлөөлдөгийг судлах болно.	AHU, Drexel university
EDUC 107	Эхний жилийн семинар: Сурган хүмүүжүүлэх арга барил			АНУ-ын дотоод болон гадаад боловсролын байдлын талаар ярилцаж, боловсролын төрөл бүрийн бүтэц, тогтолцоог төлөвшүүлэхэд арьсны өнгө, хүйсийн үүрэг, тэдгээрийн ихэнх нь бүх суралцагчдыг дэмжихэд зориулагдаагүй байж болох арга замуудын талаар ярилцах	AHU, Drexel university
EDUC 108	Эхний жилийн семинар: Сургалтын төлөвлөлт			Суралцах үйл ажиллагааг яаж төлөвлөж, хэрэгжүүлэх талаар судлах, залуучуудын оролцоо, чадавхийг бэхжүүлэх арга зам.	AHU, Drexel university
EDUC 123	Өсвөр үеийнхний хөгжил			Өсвөр үеийнхний хөгжлийн асуудлын онолыг судлах. Хичээлийн агуулга нь судалгаанд суурилсан, бодит амьдрал, соёл хоорондын жишээг ашигладаг. Онол, судалгааны хоорондын уялдаа холбоог танин мэдэх, хэрэгжүүлэх чадварыг хөгжүүлнэ. Энэхүү сургалт нь өсвөр насны хүүхдийн хөгжил, соёл, нийгэм, сэтгэл хөдлөлийн олон янзын хэрэгцээтэй холбоотой дунд, ахлах сургуулийн сургалтын зохион байгуулалтын бүтцийн талаархи ойлголтыг бий болгодог.	AHU, Drexel university
EDUC 205	Хоёр дугаар жилийн семинар			Эхний семинар дээр тулгуурлан үйлчилгээний сургалтын стратеги болгон ашиглах.	AHU, Drexel university
EDUC 216	Олон талт байдал ба өнөөгийн багш			АНУ-ын бага болон дунд ангийн сурагчдын олон янз байдал нэмэгдэж байгаатай холбоотой гол асуудлуудыг судлах. Нэг төрлийн бус суралцагчдын популяцид заах олон талт сорилтууд.	AHU, Drexel university
EDUC 305	Сурган хүмүүжүүлэх семинар /бага ангийн/			Сургалтын агуулгын мэдлэг, сурган хүмүүжүүлэх мэдлэг, суралцагчийн шинж чанар, тусгай хэрэгцээт суралцагчид, сэдэл төрүүлэх арга техник.	AHU, Drexel university
EDUC 308	Ангийн эерэг уур амьсгалыг бий болгох			Сургалтын эерэг, үр бүтээлтэй орчныг бүрдүүлэхтэй холбоотой анги танхимын менежмент, сургуулийн аюулгүй байдал болон нийгмийн бусад чухал асуудлууд судлах. Энэ хичээлийн онцлог нь "суралцагчийг таньж мэдэх", оюутны бие даасан хэрэгцээг тодорхойлох, харилцан ойлголцлыг бий болгох, "ардчилсан анги" байгуулахад чиглэнэ. Багшийн манлайлал болон бэлтгэл ажил, анги танхимыг удирдан чиглүүлэх, удирдах өөрийн арга барилыг хэрхэн хөгжүүлэх талаар суралцана.	AHU, Drexel university

EDUC 316	Хотын сургуульд заах			Хотын сургуульд нөлөөлж буй асуудлуудыг судлах. Зохион байгуулалтын бүтэц, сургалтын хөтөлбөрийг өөрчлөхөд чиглэсэн сүүлийн үеийн шинэчлэлийн хүчин чармайлтыг судлах болно. Багшийн суралцагчдад хандах хандлага, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн нөлөө, хотын орчинд багштай холбоотой мэдлэг, ур чадварт онцгой анхаарал хандуулна. Хотын сургуулийн өнөөгийн байдал, хотын сурагч болон түүний гэр бүлийг хүндэтгэх, харилцан ойлголцох.	AHU, Drexel university
EDUC 322	Үнэлгээ			Портфолио, гүйцэтгэлийн үнэлгээ, хувь хүний болон хамтарсан төсөл, илтгэл зэрэг үнэлгээний шинэ арга техникт сургах. Сурагчийн амжилтыг хэмжихэд ашигладаг чанарын болон тоон үнэлгээг заах. Танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн болон (тохиромжтой бол) моторик даалгавруудад сурагчдын хичээлийн гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах арга техникийг заадаг. Сургалт нь бага, ахлах сургуулийн орчинд заана.	AHU, Drexel university
EDUC 324	Сургалтын хөтөлбөр			Бага, дунд, ахлах ангид багшийн заах арга зүй, арга барилын үндэс болсон онол, арга зүйг судлана. Үүнд: а) математик, шинжлэх ухааны чиглэлээр мэдлэг олж авах, шүүмжлэлтэй дүгнэлт хийх, б) агуулгын материалтай холбоотой ерөнхий болон тусгай ур чадваруудыг заах, в) суралцах чадвар, чадварыг судлах, г) суралцах явцад санах ой, танин мэдэхүйн гүйцэтгэх үүрэг зэрэг агуулга багтана. Хүхдийн танин мэдэхүйн, суралцахуйн, материаллаг хэрэглэгдэхүүн, сурган хүмүүжүүлэх арга зүй, сургалтын орчин нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх талаар суралцана.	AHU, Drexel university
EDUC 365	Англи хэлгүй суралцагчдад заах арга зүй			Хоёр дахь хэл, бичиг үсэг эзэмших зарчим, онол, хос хэл, академик хэлний чадвар ба хэл шинжлэл, эдгээр зарчимд суурилсан сургалтын арга зүйг судалдаг.	AHU, Drexel university
EDUC 405	Сурган хүмүүжүүлэх ухааны семинар / ахлах ангий/			K-12 сургууль, их сургуулийн багш нар болон багш нарын хамтын ажиллагаа, суралцах үйл явцад оюутны оролцоо, сурган хүмүүжүүлэх асуудлын талаар судлах	AHU, Drexel university
EDUC 409 [WI]	Багшлах дадлага I			Ажлын бүтэн цагийн, хоёр улирлын багшийн дадалага. Сургалт нь танхимын дадалага, хяналт, эргэцүүлэн бодох дадалагаар дамжуулан багшлах мэдлэг, давуу талаа хөгжүүлэх зорилготой юм. Энэхүү дадалагаар оюутнууд эргэцүүлэн бодох тэмдэглэл хөтлөх замаар туршлагаа хуваалцаж, сургалтын шилдэг туршлагыг хэлэлцэж, нөөцийн талаар суралцаж, тухайн салбарт тулгарч буй асуудлуудыг эргэцүүлэн бодож, мэргэжлийн багшийн багц юм. Энэхүү сургалтаар оюутнууд заах арга зүй, сургалт зохион байгуулах, үүнд; төлөвлөлт, бэлтгэл, зааварчилгаа, сургалтын орчин, мэргэжлийн ур чадвар.	AHU, Drexel university
ESTM 335	Ерөнхий боловсролын сургуульд компьютерын ухаан хичээлийг заах арга зүй			Ерөнхий боловсролын сургуульд компьютерийн шинжлэх ухааныг сурах, заах гол асуудлуудыг судлана. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын практик, сургалтын онол, үнэлгээн, сургалтын хөтөлбөр зэрэг сэдвүүдээс бүрдэнэ. Хичээлийн туршид эрх тэгш байдал, хүртээмжийн асуудалд анхаарлаа хандуулах болно.	AHU, Drexel university
EDUC 220	Боловсролын үндэс			Боловсролын түүх, улс төр, хууль эрх зүй, нийгэм-соёл, философийн үндэс суурийг цогцоор нь авч үзэж, шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийж, холбооны болон муж улсын боловсролын бодлого, боловсролтой холбоотой хууль тогтоомж, олон улсын боловсролын талаархи агуулгад туссан байна. Мөн энэ хичээлийн агуулгад багшийн мэргэжлийн танилцуулга, өнөөгийн Америкийн боловсролын чиг хандлага, тулгамдсан асуудлууд ордог.	AHU, Mercer university
EDUC 283	Тусгай боловсрол			Америкийн сургуулиудын тусгай боловсролын үндсийг судалдаг. Тусгай боловсролын түүхэн хөгжил, холбогдох хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, боловсролын бодлого, орчин үеийн чиг хандлага, тулгамдсан асуудлуудыг үздэг. Энэхүү сургалт нь Жоржиа муж улсын гэрчилгээ олгох тусгай боловсролын шаардлагыг хангасан бөгөөд В ба түүнээс дээш үнэлгээтэй байх ёстой	AHU, Mercer university

EDUC 356	Өсвөр насны суралцагчийн сэтгэл зүй ба хөгжил			Өсвөр үеийнхний хөгжлийг сурах онолуудтай нэгтгэж үздэг. Уг сургалт нь өсвөр насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжил, нийгэм/сэтгэл хөдлөлийн хөгжил, сургалтын онолууд, ангийн удирдлага, сэдэл, хүмүүжлийн онол асуудлуудыг авч үздэг. Суралцахад тулгарч буй тодорхой бэрхшээлүүд болон дараагийн эмчилгээний аргуудыг мөн танилцуулсан. Сурталчилгааны асуудал болон тусгай хэрэгцээт оюутнуудыг хуралдаан бүрийн хүрээнд авч үздэг. (Жил бүр дор хаяж нэг байршилд)	AHY, Mercer university
EDUC 374	6-12-р ангид зориулсан нэгдсэн арга зүй, сургалтын хөтөлбөр			Дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг судалж. 6-12-р ангийн сурагчдын сурч боловсрол, түвшин ахих, сурагчдын олон талт хэрэгцээг хангах хичээлийн төлөвлөгөө, үнэлгээ, сургалтын стратеги зэрэг нэгдсэн/салбар дундын сургалтын хөтөлбөрийн агуулгыг сурч, хэрэгжүүлдэг.	AHY, Mercer university
EDUC 453	Бичиг үсгийн боловсрол			Өсвөр үеийнхний зөв бичих болон зөв бичиг үсгийн мэдлэгийг хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухааны чиглэлээр мэргэшсэн бичиг үсгийн ур чадваруудтай уялдуулах. Салбар хоорондын уялдаа холбоог судлах болно. Оюутнууд нарийн бичвэрүүд боловсруулах, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг сайжруулах, илтгэх чадвар суралцах. Бичиг үсгийн боловсролыг дэмжихийн тулд оюутнууд нийгэм соёлын нөхцөл байдалтай уялдуулж суралцана.	AHY, Mercer university
EDUC 398	Дадлага I			Семестрийн турш сургуульд суурилсан дадлага хийнэ. Оюутнуудыг төрөл бүрийн сургуульд хуваарилж, анги танхимтай холбоотой үйл ажиллагааг ажиглаж, оролцоход дор хаяж 35 цаг зарцуулна.	AHY, Mercer university
EDUC 399	Дадлага II			EDUC 256, 357 хичээл судалсан байна. Энэхүү сургалт нь боловсролын чиглэлээр суралцаж буй оюутнуудад семестрийн турш сургуулиас дадлага хийх боломжийг олгодог. Оюутнууд олон улсын сургуулиудад хуваарилагдах бөгөөд хамгийн багадаа 35 цагийг ажиглах, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд оролцоно.	AHY, Mercer university
EDUC 441	Хамтын ажиллагаа, салбар хоорондын төлөвлөлт, тусгай боловсролын арга зүй			EDUC 374. Дунд, ахлах ангийн багш нарын хамтын ажиллагааны хэрэгцээг судлах. Ангийн бүх суралцагчдын хэрэгцээг хангахад багш, өсвөр насныхан, эцэг эх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг практикт суурилж судална. Бүх оюутнуудад зориулсан ялгавартай, салбар хоорондын зааврыг бий болгоход онцгой анхаардаг хичээлийн хөтөлбөр.	AHY, Mercer university
